



“СУРГУУЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ”-НИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН



Улаанбаатар хот
2024 он

Үнэлгээг гүйцэтгэсэн:

Э.Оюунчимэг MD, PhD Үнэлгээний зөвлөх



Өмнөх үг

НҮБ-ын Хүүхдийн сан болон НҮБ-ын Хүн амын сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар нь сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээний үнэлгээний тайланг танилцуулж байгаадаа баяртай байна. Энэхүү тайлан нь Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сангийн нягт хамтын ажиллагааны үр дүн бөгөөд Монгол дахь ерөнхий боловсролын сургуулиудын хүүхэд, өсвөр үеийнхний сайн сайхан байдлыг хангахад чиглэсэн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай үйлчилгээгээр хангахын төлөөх хамтын хүчин чармайлт юм.

Сургууль нь сурагчдын эрүүл мэнд, хөгжлийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд эрүүл мэндийн үйлчилгээг өргөн цар хүрээтэй хүргэх өвөрмөц платформ юм. Монгол Улс сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээг бий болгоход ахиц дэвшил гаргасан ч боловсрол, эрүүл мэндийн салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, тэгш хүртээмжийг, хангах зэрэг бэрхшээлүүд тулгарсаар байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэх нь сурагчдын бие бялдар, оюун санаа, нийгмийн хувьд хөгжин дэвжих таатай орчинг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.


Энэхүү үнэлгээний тайлан нь Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулиудын үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээний өнөөгийн байдлыг тодорхойлон, цаашид сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг дэвшүүлж байна. Тайланд бодлогыг стандартчилах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, сургуулийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн практик зөвлөмжийг тусгасан. Эдгээр зөвлөмж нь шийдвэр гаргагчид, түнш байгууллагууд, хандивлагчдад сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээг бэхжүүлэх хөрөнгө оруулалтын чиглэлийг тодорхойлоход чиглүүлж, ингэснээр Монголын сурагч бүр амжилтанд хүрэхэд шаардлагатай тусламж, дэмжлэг авах боломжтой болно.

Энэхүү чухал санаачилгыг дэмжин, үнэлгээг амжилттай хэрэгжүүлэхэд тууштай ажилласан Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам болон НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан болон үнэлгээний багийнханд чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье.

Цаашид бид Монгол Улсын Засгийн газар болон түнш байгууллагуудтай хамтран хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэнд, хөгжлийг дэмжихэд чиглэсэн эдгээр зөвлөмжийг бодит ажил болгохын төлөө чармайн ажиллах болно. Монголын бүх сурагчид эрүүл саруул өсөж, амжилттай суралцаж, нийгэмдээ үнэтэй хувь нэмэр оруулах ирээдүйг хамтдаа бүтээж чадна гэдэгт бид итгэлтэй байна.


Др. Халид Шарифи

НҮБ-ын Хүн амын сангийн тэргүүн



Эваристе Коуасси-Комлан

НҮБ-ын Хүүхдийн сангийн суурин төлөөлөгч



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ФБХ	Фокус бүлгийн хэлэлцүүлэг
ЕБС	Ерөнхий болосролын сургууль
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
БЕГ	Боловсролын Ерөнхий газар
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
НЭМҮ	Нийгмийн Эрүүл мэндийн үйлчилгээ
НЭМҮТ	Нийгмийн Эрүүл мэндийн үндэсний төв
СЭМҮ	Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээ
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
УБ	Улаанбаатар
НҮБ-ын БШУСБ	НҮБ-ын Боловсрол шинжлэх ухааны, соёлын байгууллага
НҮБ-ын ҮБ	НҮБ-ын Үнэлгээний бүлэг
НҮБ-ын ХАС	НҮБ-ын Хүн амын сан
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага

МОНГОЛ ДАХ СУРГУУЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

ТОЙМ

1. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

- 1.1 Үндэслэл
- 1.2 Монгол дах сургуулийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж
- 1.3 Үнэлгээний ерөнхий болон дэд зорилгууд

2. ҮНЭЛГЭЭНИЙ МАТЕРИАЛ, АРГА ЗҮЙ

- 2.1 Ажлын цар хүрээ
- 2.2 Үнэлгээний байршил, түүвэр
- 2.3 Арга, аргачлал ба дүн шинжилгээ
- 2.4 Хязгаарлагдмал тал
- 2.5 Мэдээллийн найдвартай болон хүчин төгөлдөр байдал
- 2.6 Үнэлгээний ёсзүй

3. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

- 3.1. Улс орны хууль, эрхзүйн орчин, баримт бичгийн хүрээнд сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээний тусгагдсан байдал
- 3.2. Сургуулиар дамжуулан үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээний өнөөгийн механизм, бодлого боловсруулагч, үйлчилгээ үзүүлэгчдийн байр суурь
- 3.3. Сургуулиар дамжуулан үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээний нөхцөл байдал
- 3.4. Сургуулиар дамжуулан үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээг хүлээн авагчдын ойлголт, хүлээлт

4. ДҮГНЭЛТ

5. ЗӨВЛӨМЖ

6. ЭХ СУРВАЛЖ,

7. ХАВСРАЛТУУД

- Хавсралт 1. Баримт бичгийн үнэлгээний загвар
- Хавсралт 2. Түлхүүр мэдээлэгчийн ярилцлагын хуудас
- Хавсралт 3. Сургуулийн эмч, ажилтны ярилцлагын хуудас
- Хавсралт 4. Ажиглалтын хяналтын хуудас
- Хавсралт 5. Эцэг, эх/ асран хамгаалагчдын ярилцлагын хуудас



Хавсралт 6. Фокус бүлгийн ярилцлагын хуудас

Хавсралт 7. Өсвөр үеийн кабинетийн эмчийн ярилцлагын хуудас

Хавсралт 8. Таниулсан зөвшөөрлийн хуудас

Дүрслэл

Дүрслэл 1. Сонгогдсон аймгуудын газарзүйн байршил

Дүрслэл 2. Сонгогдсон дүүргийн газарзүйн байршил

Дүрслэл 3. Улсын хууль эрх зүйн орчин

Хүснэгт

Хүснэгт 1. Монгол Улс дахь сургууль, сурагчийн тоо байршлаар

Хүснэгт 2. Үнэлгээний сонгогдсон сургуулийн тойм мэдээлэл

Хүснэгт 3. Үнэлгээнд оролцогчдын тойм мэдээлэл

Хүснэгт 4. Дүн шинжилгээ

Хүснэгт 5. Хууль тогтоомжийн онцлог

Хүснэгт 6. ДЭМБ-ын үр дүнгийн харьцуулалт ба зөрүү

Хүснэгт 7. Сургуулиудын эрүүл мэндийн үйлчилгээний нөөц, нөхцөлийг өмчлөлөөр нь харьцуулсан байдал

Хайрцаг

Хайрцаг 1. Үнэлгээний газрыг сонгох үндсэн шалгуурууд (аймаг, нийслэлийн дүүрэг)

Хайрцаг 2. Оролцогчдыг үнэлгээнд хамруулах шалгуур

Хайрцаг 3. Үнэлгээ хийх орчин ба тоног төхөөрөмж

Зураг

Зураг 1. Үнэлгээнд хамрагдсан зарим сургууль

Зураг 2. Эмч нарын бичиг хэргийн шүүгээ

Зураг 3. Эмчийн төлөвлөгөө, тайлан материалууд

Зураг 4. Эмчийн өрөөний хэрэглэгдэхүүн

Зураг 5. Сургалт, сурталчилгааны материал

Зураг 6. Эмчийн бүртгэл, үзлэгийн дэвтэр



НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Таниулан зөвшөөрлийн хуудас нь судалгаа, үнэлгээ, хөндлөнгийн оролцоо зэрэгтэй холбоотой ёс суртахууны талаар хөнддөг учир бичгээр зөвшөөрөл авах үйл явцын нэг төрөл юм. Энэ нь судалгааны мэдээлэл болон эрсдэл, ашиг тус, нөхцөлийн талаарх мэдээллийг агуулдаг.

Сургуулийн ажилтан гэдэг нь тухайн сургуультай албан ёсоор гэрээ байгуулсан албан хаагчийг хэлнэ.

Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээ гэдэг нь ДЭМБ-ын удирдамжийн дагуу боловсрол эзэмшиж буй сурагчдад сургуулийн дотор эсвэл гадуурх орчинд эрүүл мэндийн ажилтны үзүүлэх үйлчилгээ юм.

Сурагч гэдэг нь албан ёсоор сургуульд элсэн суралцаж байгаа хүүхэд юм.

Сургуулийн эмч нь анагаах ухааны боловсрол эзэмшсэн, сурагчдад эмнэлгийн анхны тусламж үзүүлэх үүрэгтэй мэргэжилтэн. Сурагчид төдийгүй тус сургуулийн ажилтнуудад нийгмийн эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг үзүүлдэг мэргэжилтэн юм.

Эцэг эх/асран хамгаалагч нь сурагчдын хууль ёсны асран хамгаалагч юм.



НЭГ. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

1.1. ҮНДЭСЛЭЛ

Сургууль нь хүүхэд, залуучуудад эрүүл ирээдүйн үндэс суурь болох мэдлэг, нийгэм-сэтгэлзүйн чадварыг эзэмшүүлэхэд зайлшгүй шаардлагатай орчин юм. Сургуулийн аюулгүй, дэмжлэгтэй орчин нь эрүүл мэндэд сайн үр дүнг бий болгодог. Эрүүл оюутнууд сургууль завсардалт бага, боловсролын үзүүлэлт өндөр, бүтээмж, ирээдүйд илүү сайн ажилтай холбоотой байдаг. [1]

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-аас тодорхойлсон “Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээ (СЭМҮ) гэдэг нь бага, дунд боловсрол хамрагдаж буй сурагчдад сургуулийн байранд эсвэл сургуулиас гадуур байрлах эрүүл мэндийн үйлчилгээнд эрүүл мэндийн ажилтны үзүүлж буй үйлчилгээ юм. Улс орнуудад СЭМҮ-н янз бүрийн хэлбэрүүд байдаг боловч эдгээр хөтөлбөрүүдийн ихэнх нь одоогоор шинжлэх ухааны үндэслэлгүй, төлөвлөгдөөгүй, санхүүжүүлэлтгүй байна. Мөн эдгээр хэлбэрийн СЭМҮ-н хүртээмж, хамрах хүрээ хязгаарлагдмал байна. Мөн ДЭМБ 1995 онд сургуулиудын эрүүл мэндийг дэмжих арга барилыг бэхжүүлэх зорилгоор Дэлхийн сургуулийн эрүүл мэндийн санаачилгыг санаачилсан. Харамсалтай нь сурагчид осол гэмтэл, хүчирхийлэл, бэлгийн, нөхөн үржихүйн болон сэтгэцийн эрүүл мэнд, халдварт болон халдварт бус өвчин зэрэг урьдчилан сэргийлэх боломжтой эрүүл мэндийн янз бүрийн асуудалтай тулгардаг. Сурагчид бага наснаасаа эхлэн нас биенд хүртлээ хөгжих үе шатанд эерэг туршлага, дэмжлэг хэрэгтэй. Гэсэн хэдий ч эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хамрах хүрээ дэлхий хэмжээнд хязгаарлагдмал хэвээр байна. Тиймээс сургуулиуд сурагчдад эрүүл мэндийн үр дүнтэй үйлчилгээг өргөн хүрээнд хэрэгжүүлэх онцгой боломжийг олгож магадгүй юм. [1]

НҮБ-ын Хүүхдийн сангаас гаргасан тайланд Монгол улс дахь сургуулийн насны хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийн үйлчилгээний ачаалал, хэрэгцээ шаардлага өндөр байгааг онцолжээ. Тухайлбал Монгол Улсын сургуулийн насны хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийн хувьд ялгаа байгаа бөгөөд хөдөө орон нутгийн болон нийгэмд гадуурхагдсан хүн ам чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад илүү их бэрхшээлтэй тулгарч байгааг онцлон тэмдэглэжээ. Мөн Монгол улсын сургуулийн хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийн хэрэгцээг илүү сайн хангахын тулд эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, эрүүл мэндийн дэд бүтцэд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийг уриалсан байна.[2] Монгол Улсын хэмжээнд 6-11 насны өсөлтийн хоцрогдолтой, тураалтай хүүхдүүдийн

эзлэх хувь 7.3%, 2.8% байна. Сургуулийн 6-11 насны хүүхдийн илүүдэл жин, таргалалтын тархалт 2010 оны түвшнээс эрс нэмэгдэж, 22.2%, 6.4%-д хүрчээ. Эрүүл бус хоол хүнс, ундаа хэрэглэх нь 6-11 насны бүлэгт түгээмэл тохиолдож буй бөгөөд бараг бүх хүүхдүүд (99.2%) долоо хоногт нэг удаа эрүүл бус хоол хүнс, ундаа хэрэглэдэг байна. Тодруулбал, 10 хүүхэд тутмын 8 нь чихэрлэг ундаа, шарсан хоол хүнс хэрэглэдэг нь тогтоогдсон байна. Сургуулиудын 93.4% нь сургалтын хөтөлбөртөө биеийн тамирын хөтөлбөрийг тусгаж, сургуулийн хүүхдүүдийн 98.6% нь хөтөлбөрт хамрагдсан байна.[3]

1.2. МОНГОЛ УЛСАД СУРГУУЛЬД СУУРИЛСАН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Монгол Улсын ерөнхий боловсролын зорилго нь бие даан суралцах, амьдрахад шаардлагатай суурь мэдлэг, ур чадварыг төлөвшүүлэх, ирээдүйд ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжилтэй иргэн болгон төлөвшүүлэхэд оршино. Ерөнхий боловсролд улсын хэмжээнд 12 жилийн бага, суурь, дунд боловсрол багтдаг. [4]

Ерөнхий боловсролын сургуульд тухайн жилдээ зургаан нас хүрсэн хүүхдүүдийг элсүүлнэ. Иймд насны бүлгээр 6-10 нас бага ангийн боловсролд 1-5-р анги, 11-14 нас, дунд болон суурь боловсрол 6-9-р анги, 15-17 нас, ахлах болон бүрэн дунд боловсрол 10-12-р анги гэж ангилдаг. [4]

Орон нутгийн нөхцөл байдлын хувьд зарим сумдад 9-р ангийн суурь боловсрол олгох сургууль л байдаг. Иймд сурагчид бүрэн дунд боловсрол эзэмшихээр ихэвчлэн хэд хэдэн сумын дунд, аймгийн төвд байрлах дараагийн шатны сургуульд шилжин суралцдаг.

Ерөнхий боловсролын сургуульд захирал, сургуулийн менежер, сургуулийн эмч, нийгмийн ажилтан, багш, сэтгэл зүйч, номын санч болон холбогдох хуульд заасан бусад ажилтнууд ажилладаг.

Ажлын байрны тодорхойлолтын хувьд

- Сургуулийн нийгмийн ажилтан нь сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр сурагчид, тэдний эцэг, эх, асран хамгаалагч, дэмжигчдэд нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг үзүүлнэ.
- ЕБС-ийн сэтгэл зүйч нь сурагчдын сэтгэл зүйн асуудлыг шийдвэрлэхэд тусалж, ганцаарчилсан сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх
- Сургуулийн хоол зүйч нь сурагчид, ажилчид, эцэг эхчүүд, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний удирдлагуудад мэргэжлийн зөвлөгөө өгөх, хоолны цэс, өдөр тутмын технологид



анхаарал хандуулна.

- Харин, сургуулийн эмч нь сурагч, ажиллагсдад эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг. [4,5]

Эрүүл мэндийн сайдын 2017 оны Өсвөр үе, залуучуудад үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ, арга хэмжээний тухай А399 тоот тушаалын дагуу эрүүл мэндийн кабинет нь сургуулийн сурагчдад үйлчилгээ үзүүлдэг. Гэвч хүний нөөцийн хомсдол болон бусад нөхцөл байдлаас шалтгаалан эмнэлгүүдийн нөхцөл байдал харилцан алдилгүй байдаг байна.

Гэсэн хэдий ч Монгол Улсад эрүүл мэнд, боловсролын салбарт тогтвортой бодлогоор дэмжигдсэн сургуулийн эрүүл мэндийн нэгдмэл, нарийвчилсан үйлчилгээ Монголд хараахан бий болоогүй байна. [6,7] СЭМҮ-н хууль эрхзүйн орчныг мөрдүүлж, бэхжүүлэх шаардлагатай. 2023 оны 6-р сард батлагдсан боловсролын тухай хуульд орсон өөрчлөлтүүд нь сургуулийн эрүүл мэндийн тандалтын тогтолцоог илүү бат бөх болгох алхам болж байгаа нь анхаарал татаж байна[2,3]. Түүнчлэн ерөнхий боловсролын бүх сургуулийг эмчтэй болгох бодлого, санаачилга үргэлжилэн хэрэгжиж байна. . [4,5] Гэсэн хэдий ч сургуулийн эмч нарын үүрэг нь оюутнуудын амны хөндийн эрүүл мэнд, эрүүл ахуйд түлхүү чиглэгдсэн, ажлын байрны тодорхойлолт нь илүү өргөн хүрээтэй байдаг. Нэмж дурдахад, сургуулийн одоогийн эрүүл мэндийн үйлчилгээ нь газарзүйн байршил, сургуулийн өмчийн хэлбэрээс хамаарч өөр өөр байдаг.

Манай улсын ЕБС-д суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ, тусламжийн өнөөгийн байдлын талаар хийсэн судалгаа цөөхөн байна. Ялангуяа үйлчилгээ үзүүлэгчдийн тулгамдаж буй бэрхшээл, дутагдал, үйлчилгээ хүлээн авагчдын тэргүүлэх чиглэл, хэрэгцээг хамтад нь судлаж, тодорхойлоогүй байна. Тиймээс ирээдүйн төлөвлөлтийн үндэс болгон сурагчдад зориулсан одоо байгаа СЭМҮ-г судлах хэрэгцээ тулгамдаж байна.

1.3 ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Үнэлгээний ерөнхий зорилго нь Монгол улс дахь сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээг бэхжүүлэх чиглэлүүдийг судлахад оршино.

ЗОРИЛГО 1: Сургуулийн эрүүл мэндийн үзэл баримтлалт, агуулга, ойлголтыг Эрүүл мэндийн яам, Боловсролын яамны хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөрийн хүрээнд авч үзэх

ЗОРИЛГО 2: Сургуулиар дамжуулан эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх өнөөгийн механизм, давуу тал, дутагдалтай тал, сайжруулах



зөвлөмжийн талаар бодлого боловсруулагчид, сургуулийн удирдлага, ажилтнуудын болон өсвөр үе, залуучуудын кабинетийн эмчийн санал бодлыг судлах

ЗОРИЛГО 3: Сонгогдсон сургуулиудын дэд бүтэц, үзүүлж буй үйлчилгээ, тандалт, хяналт, шилжүүлэг, бүртгэл, тайлагнах механизм зэрэг эрүүл мэндийн үйлчилгээний бодит байдалд үнэлгээ хийх

ЗОРИЛГО 4: Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээ, тэргүүлэх чиглэлийн талаар сурагчид, эцэг эхчүүдийн санал бодол, хэрэгцээг судлах

ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ МАТЕРИАЛ, АРГА ЗҮЙ

2.1. АЖЛЫН ХҮРЭЭ

- 1) Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой одоо байгаа хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр, баримт бичгийг судалж, сүүлийн үеийн хууль тогтоомжийн шинэчлэлд анхаарал хандуулах
- 2) Бодлого боловсруулагчид, сургуулийн ажилтнууд, өсвөр үе, залуучуудын кабинетийн эмч, сурагчид, эцэг эхчүүдтэй ярилцлага хийх
- 3) Сурагчдын эрүүл мэндийн хэрэгцээ, хуулийн шинэ заалтын хэрэгжилтийг сургуулийн эрүүл мэндийн холбогдох дэд бүтцийн хүрээнд үнэлэх
- 4) Сургуулиудад очиж эрүүл мэндийн үйлчилгээ, тоног төхөөрөмж, нөөцийн талаар үнэлгээ хийх
- 5) Сургуулийн өнөөгийн эрүүл мэндийн үйлчилгээг баримт бичгийн үнэлгээ, сургууль дах ажиглалт, үнэлгээнд оролцогчдын ярилцлагыг нэгтгэн тодорхойлох
- 6) Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээний өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, үнэлгээний үр дүнг холбогдох оролцогч талуудад танилцуулах
- 7) Дүгнэлт, хэлэлцүүлэгт үндэслэн сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газрын стратегийн зорилт, олон улсын жишигт нийцүүлэн боловсруулахад хувь нэмэр оруулах



2.2. ҮНЭЛГЭЭНИЙ ТҮҮВЭР, БАЙРШИЛ

Үндэсний статистикийн хорооноос мэдээлснээр 2022 оны байдлаар нийт 859 сургуульд 746,405 хүүхэд суралцаж, өмчийн хувьд төрийн өмчийн 695, хувийн өмчийн 176 сургууль байна.

Газарзүйн байршлын хувьд хөдөө орон нутгийн 562 сургуульд нийт 381612 сурагч суралцаж байна. 2022 оны мэдээгээр нийслэлийн хэмжээнд 297 ерөнхий боловсролын сургуульд 364,793 сурагч суралцаж байна [8]

Хүснэгт 1. Монгол Улс дахь сургууль, сурагчийн тоо, байршлаар

Аймаг/ Дүүрэг	Нийт хүн ам	Хүн амын нягт	Орон зай	Засаг захиргааны нэгж (сум/хороо)	Нийт сургуулийн тоо	Нийт сурагчийн тоо
Архангай	93149	1.7	55,300	19	30	19461
Баян-Өлгий	114962	2.2	45,700	13	44	25918
Баян-хонгор	88397	0.7	116,000	20	33	18695
Булган	61161	1.2	48,700	16	22	11401
Говь-Алтай	57098	0.4	141,400	18	28	11837
Говьсүмбэр	18007	3	5,540	3	5	4267
Дархан-Уул	107932	30.6	3,280	4	25	24500
Дорноговь	71129	0.6	109,500	14	22	15321
Дорнод	83704	0.6	123,600	14	27	18956
Дундговь	46387	0.6	74,700	15	19	8733
Завхан	71798	0.8	82,500	24	30	15778
Орхон	109125	119.9	840	2	24	24644
Өвөрхангай	114962	1.8	62,900	19	32	24439
Өмнөговь	72937	0.4	165,400	15	22	15659
Сүхбаатар	65214	0.7	82,300	13	16	13783
Сэлэнгэ	107341	2.6	41,200	17	35	21953
Төв	92038	1.2	74,000	27	32	18590
Увс	83964	1.2	69,585	19	29	19335
Ховд	91071	1.1	76,060	17	25	20966
Хөвсгөл	136633	1.3	100,628	24	35	30424
Хэнтий	78959	0.9	80,325	17	27	16952
Багануур	29433	0.5	62020	5	4	6882
Багахангай	4459	0.3	14000	2	1	784
Баянгол	236385	0.4	659,600	23	50	59213
Баянзүрх	383892	3.1	124,410	43	65	92392
Налайх	38929	0.6	68760	7	8	8935



Сонгино-Хайрхан	341540	2.8	120,060	32	35	64851
Сүхбаатар	144542	6.9	20840	20	52	46410
Хан-Уул	209524	4.3	48470	25	53	54432
Чингэлтэй	150548	16.9	8930	24	29	30894
Нийт					859	746 405

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022 он

НҮБ-ын Хүн амын сангийн ажлын удирдамжийн дагуу үнэлгээ хийх газрыг зорилтот түүврийн аргыг сонгосон. Сургуульд очиж хийх үнэлгээг Улаанбаатар хотын 3 сургууль болон хөдөө орон нутгийн төлөөлөл болох 2 аймаг, 1 сумыг сонгосон. НҮБ-ын Хүн амын сангийн багтай зөвшилцсөний үндсэн дээр сонгон шалгаруулах үндсэн шалгууруудыг (доорх Хүснэгт 1) эцэслэн гаргаж, үнэлгээний газарт Өвөрхангай, Говь-Алтай аймаг (аймгууд), нийслэлийн Баянзүрх дүүргийг сонгосон.

Хайрцаг 1. Үнэлгээний газрыг сонгосон үндсэн шалгуур (аймаг, нийслэл)

- Хүн амын нягтрал;
- Газарзүйн болон бүс нутгийн төлөөлөл;
- УБ хотоос алслагдсан байдал;
- Сургуулийн өмчлөлийн хэлбэр;



Зураг 1. Сонгогдсон аймагуудын газарзүйн байршил





Зураг 2. Сонгогдсон дүүргийн газарзүйн байршил

Сонгосон үнэлгээний газруудын холбогдох мэдээллийг Хүснэгт 2-т үзүүлэв.

Хөдөө орон нутгийн сургуулуудийн талаарх гол хүчин зүйл, онцлог, газар зүйн байршлыг УБ хотоос тооцоолсон.

Хүснэгт 2. Үнэлгээний газруудын тойм мэдээлэл

Сонгосон байршил болон сургууль		Үндсэн шинж чанар, онцлог	Байршил (УБ хотоос)
Дүүрэг	Баянзүрх дүүргийн, 79-р сургууль	Гэр хорооллын улсын сургуулиудын төлөөлөл	-
	Баянзүрх дүүргийн, 21-р сургууль	Орон сууцны хорооллын улсын сургуулиудын төлөөлөл Сурагчдын тоо их	-
	Баянзүрх дүүргийн, Эрхэт эрдэм хувийн сургууль	Хувийн сургуулийн төлөөлөл	-
Аймаг	Өвөрхангай	Алслагдсан байдал	430 км
	Говь-Алтай	Алслагдсан байдал	1636 км
	Сумын сургууль	Алслагдсан байдал	

Энэхүү мэдээлэл цуглуулах ажлыг 2024 оны 2, 3-р сард гурван долоо хоногийн хугацаанд хийсэн бөгөөд тус үнэлгээнд 29 хүнийг хамруулсан.



Оролцогчдын тооцоолсон тоо нь түлхүүр мэдээлэгчийн ярилцлагад 3, ганцаарчилсан ярилцлагад 20, фокус бүлгийн 3 удаагийн хэлэлцүүлэгт нийт 9 сурагч оролцсон. (Дэлгэрэнгүйг Хүснэгт 3-аас үзнэ үү)

Хүснэгт 3. Үнэлгээнд оролцогчдын тойм мэдээлэл

Байршил	Мэргэжилтэн	Өсвөр үеийн кабинет	Сургуулийн удирдлага, багш нар	Эмч	Сэтгэл зүйч	Сурагч	Эцэг эх	Нийт
Улаанбаатар (БШУЯ &ЭМЯ)	3							3
Дүүрэг				1		ФБХ-3		4
Дүүрэг		1		1				2
Дүүрэг			1	1			1	3
Өвөрхангай			1	1	1	ФБХ- 3		6
Говь-Алтай			2	1			1	4
Сум 1			1	1	1	ФБХ 3	1	7
Нийт	3	1	5	6	2	9	3	29

2.3. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА, МАТРИЦ

Мэдээлэл цуглуулахад дараах чанарын судалгааны аргуудыг ашигласан.

- 1) Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой одоо мөрдөж буй хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр, удирдамжийн баримт бичгийг судлах;
- 2) Засгийн газрын бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгчид, сургуулийн ажилтан (менежер, багш, сургуулийн эмч, сургуулийн сэтгэлзүйч) болон өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн кабинетийн эмчтэй “үйлчилгээ үзүүлэгчид”-ийн төлөөлөл болгон ярилцлага хийх;
- 3) Сурагчидтай фокус бүлгийн хэлэлцүүлэг, эцэг эх, асран хамгаалагчдын төлөөлөгчидтэй “үйлчилгээний ашиг хүртэгчид”-ийн төлөөлөл болгон ганцаарчилсан ярилцлага тус тус хийх;
- 4) Сонгосон сургуулиудад хяналтын хуудас ашиглан ажиглалт хийх

1. Хууль, эрхзүйн баримт бичгийн үнэлгээ

Баримт бичигийн үнэлгээ нь Зорилт 1 болон зорилт 3-ыг шийдвэрлэх



зорилготой болно. Баримт бичигийн үнэлгээнд дараах тодорхой ажлуудыг хамруулсан:

- ДЭМБ, ЮНЕСКО-гийн СЭМҮ-ийн стратегийн удирдамж зэрэг олон улсын баримт бичгүүдийг жишиг болгон судлах;
- Хууль тогтоомжийн өөрчлөлт, бодлогын агуулга, дутагдлыг илрүүлэхийн тулд үндэсний хууль тогтоомж, бодлого, стандарт, хөтөлбөр, удирдамжийг судалж үзэх. Үүнийг сургууль, сургуулийн эмч, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой түлхүүр үгсийг ашиглан албан ёсны вэб сайтууд, тухайлбал яамдын вэб сайтууд болон legalinfo.mn сайтуудаар интернетээр хайлт хийж гүйцэтгэсэн.
- НҮБ-ын Хүн амын сангийн баг болон яам, агентлагуудын холбогдох ном, баримт бичигт хандах, тэдгээрийг чухал эх сурвалж болгон ашиглах;
- Баримт бичигийн үнэлгээний загвар (Хавсралт-1. Баримт бичигийн үнэлгээний загвар)-ийг ашиглан үндсэн дүгнэлтүүдийг нэгтгэн боловсруулах. Энэхүү загварыг НҮБ-ын Хүн амын сангийн ХАБ-ын баг шинэчилж, баталсны дараа ашигласан. Загвар нь 20 боломжит бүрэлдэхүүн хэсэг бүхий 4 үндсэн хэсгээс бүрдэнэ.

2. Ганцаарчилсан ярилцлага

Ганцаарчилсан ярилцлага нь үнэлгээний **Зорилго-2 болон 4-д** чиглэгдсэн ба бүх ярилцлагыг оролцогчидтой нүүр тулан явуулсан. Хавсралт тус бүрт ганцаарчилсан ярилцлагын Чиглүүлэх асуултыг боловсруулан оруулсан. Үүнд:

- **Хавсралт 2.** Тус ярилцлагын чиглүүлэх асуултыг НҮБ-ын Хүн амын сангаас тодорхойлсон үнэлгээний хамрах хүрээнд, СЭМҮ-н хууль эрх зүйн болон бодлогын зохицуулалтын хүлээгдэж буй хэрэгцээ, дутагдлыг тодорхойлох, бодлого боловсруулагч болон хэрэгжүүлэгч нарын үзэл бодлыг сонсох зорилгоор боловсруулсан. Оролцогчдыг сонгон шалгаруулахдаа яам, холбогдох агентлагаас СЭМҮ-н холбогдох ажлыг эрхэлдэг хүмүүсийг зорилтот байдлаар түүвэрлэсэн.
- **Хавсралт 3.** Сургуулийн эмч, ажилтнуудад зориулсан ярилцлагын чиглүүлэх асуумжыг үнэлгээний хамрах хүрээнд боловсруулж сургуулийн ажилтнуудыг санамсаргүй байдлаар сонгон шалгаруулсан.
- **Хавсралт 5.** Эцэг эх/асран хамгаалагчдад зориулсан ярилцлагыг СЭМҮ-н талаарх үндсэн ойлголт, тэдний санал



бодол, хүлээгдэж буй хэрэгцээг тодорхойлж, СЭМҮ-ийн дутагдлыг үнэлэх зорилгоор боловсруулж оролцогчдыг хамруулах шалгуурыг харгалзан, боломжид тулгуурлан санамсаргүй байдлаар сонгон хамруулсан. (**Хайрцаг 2**)

- **Хавсралт 7.** Өсвөр үеийн кабинетийн эмчийн ярилцлага нь сургуулийн болон сурагчдын эрүүл мэндийн талаарх санал бодлыг тодорхойлох, нэмэлт мэдээлэл өгөх зорилготой боловсруулагдсан.

Хайрцаг 2. Оролцогчдыг хамруулах шалгуур

- Оролцохыг зөвшөөрсөн байх
- Таниулсан зөвшөөрлийн хуудсыг бөглөсөн байх
- Сонгосон сургуульд дор хаяж нэг жилийн өмнө сурагч/ажилтнаар элсэн орсон байх
- Сургууль болон ажил 1 сараас дээш хугацаагаар завсарлаагүй байх

а. Фокус бүлгийн хэлэлцүүлэг (ФБХ)

Фокус бүлгийн хэлэлцүүлгээр сурагчдаас СЭМҮ-н бодит туршлага, ирээдүйн хүлээгдэж буй хэрэгцээ, ач холбогдол өгч буй чухалд тооцогдох үйлчилгээний талаар тодруулж **Зорилго 4**-д хүрэхэд чиглэн боловсруулсан.

Сонгосон 3 сурагчыг бүлэг болгон **Хавсралт 6**-г хэрэглэгдэхүүн болгон ашиглаж ФБХ хийнэ. Оролцогчдыг сонгох шалгуур (Хайрцаг 2-т), харин үнэлгээний өрөө, тоног төхөөрөмжийн үндсэн хэрэгцээг (Хайрцаг 3-т) тус тус тодорхойлсон.

Хайрцаг 3. Үнэлгээнд шаардагдах орчин, тоног төхөөрөмж

- Ярилцлага хийх тусдаа өрөө
- Аудио бичигч
- Цаас, үзэг
- Савтай ус
- Цаг

б. Ажиглалт

Ажиглалтын аргаар сургуулийн дэд бүтэц, үйлчилгээ үзүүлэх боломжтой нөөцийг тодорхойлж зорилго 3-д чиглүүлэн боловсруулсан. Нэмж дурдахад зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүн, хувийн зөвлөгөө өгөх талбай, мэдээлэл, боловсрол, харилцаа холбооны (ИЕС) материал, түүнчлэн хөндлөнгийн оролцоо, үйлчилгээний бусад нөөцийн хүртээмж, ашиглалтыг үнэлэв. Цаашлаад сурагчын үнэмлэх, сургалтын хуваарь, эрүүл мэндийн үзлэгт хамрагдах



жилийн төлөвлөгөө, холбогдох бодлогын баримт бичгүүдтэй танилцлаа.

Хавсралт 4. Ажиглалтын хяналтын хуудас нь нийт 5 бүлэг 44 асуулт бүхий шалгах хуудас бөгөөд бид тус хуудасыг боловсруулахдаа ажлын удирдамжийг удирдлага болгож, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, сургуулийн эмчийн ажлын байрны тодорхойлолтыг үндэслэсэн.

Мэдээлэл цуглуулах хуудасыг боловсруулахдаа тодорхойлсон ажлын цар хүрээ, зорилтод тулгуурлан чиглүүлсэн. Цаашилбал, СЭМҮ-тэй холбоотой хууль тогтоомжууд нь хөгжүүлэх чухал тусгал юм.

ҮНЭЛГЭЭНИЙ МАТРИЦ нь мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх ерөнхий удирдамж өгөх зорилготой нэгдсэн тойм юм. Мэдээлэл цуглуулах хэрэгсэл бүрийг хавсаргасан (Хавсралт 1- 8-д) болно.

ДҮН ШИНЖИЛГЭЭ. Чанарын аргаар цуглуулсан мэдээлэлд 5-р хүснэгтэд үзүүлсний дагуу дүн шинжилгээ хийв.

Хүснэгт 4. Дүн шинжилгээ

Хууль, эрхзүйн холбогдох баримт бичгийн үнэлгээ	Холбогдох үндсэн бодлогын баримт бичгүүдийг үндсэн болон дэд хэсэгт хуваан дескриптив судалгааны аргаар дүн шинжилгээг хийв.
Ганцаарчилсан ярилцлага	Ярилцлагын мэдээллийг кодлон Микрософт эксэл програмд оруулж улмаар үндсэн дэд сэдэв, сэдэвт бүлэглэн дүн шинжилгээ хийсэн. Оролцогчдын холбогдох таних мэдээллийг нууцласан.
ФБХ	
Ажиглалт	Ажиглалтын аргаар цуглуулсан мэдээллийг дескриптив аргаар дүн шинжилгээг хийсэн. 5 үндсэн бүлгийн дагуу дүгнэсэн.

2.4 ХЯЗГААРЛАГДМАЛ ТАЛ

- Тус үнэлгээн дэх ярилцлагын түүврийн хэмжээ бага тул бүх сургуулийн нийтлэг, ерөнхий байдлыг харуулах, үр дүнгээр ерөнхийлөн дүгнэлт хийх боломжгүй. Гэхдээ ярилцлагын аргаар бодит, үнэ цэнэтэй мэдээллийг, үндсэн нөхцөл байдлыг тодруулах боломжтой.
- Үнэлгээнд сургуульд үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээг сурагчид болон эцэг эхчүүдийн хэрэгцээ, тэргүүлэх чиглэл зэргийг хамруулна. Түүврийн хэмжээ бага, цаг хугацаа хязгаарлагдмал зэргээс шалтгаалан зарим хариулт нь бодит туршлага, үйлчилгээг бүрэн тусгаагүй байх магадлалтай.
- СЭМҮ-ийн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухайд төсөв, санхүүгийн мэдээлэл зайлшгүй шаардлагатай боловч энэхүү үнэлгээгээр төсөв, зарцуулалтын асуудлыг хамрахгүй юм.



2.5 ҮНЭЛГЭЭНИЙ НАЙДВАРТАЙ БОЛОН ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙДАЛ

Мэдээллийг чанар, найдвартай болон хүчин төгөлдөр байдлыг хангахын тулд дараах нь хэд хэдэн алхмуудыг авч хэрэгжүүлсэн.

- **Үнэлгээний арга, аргачлал, мэдээлэл цуглуулалт:** Судалгааны зорилго болон үндсэн зорилтуудад тулгуурлан үнэлгээний арга, аргачлалыг олон улсад (ОУ) хэрэглэгддэг, тохиромжтой, түгээмэл байдлыг харгалзан сонгосон. Улмаар НҮБ-ын ХАС-ийн Өсвөр үе, залуучуудын баг сайтар хянах болон зөвшөөрсний дараа бүх үнэлгээний арга аргачлал, асуумж, ажиглалтын хуудсыг эцэслэсэн. Холбогдох баримт бичгийг албан ёсны цахим эх сурвалж, тамга тэмдгээр баталгаажсан байдлаар нягтласан.
- **Үнэлгээний матриц:** Үнэлгээний зорилго болон хүрэх үр дүнд тулгуурлан асуултыг тодорхойлон гаргаж үнэлгээний матрицыг боловсруулсан. Зорилго тус бүрээр асуумж болон ажиглалтын хуудсыг холбогдох ОУ болон үндэсний хэмжээнд мөрдөж буй заавар, хууль, стандартыг харгалзан боловсруулсан.
- **Урьдчилсан туршилт:** Үнэлгээний асуумж, ажиглалтын хуудсын урьдчилсан туршилтыг захирлын зөвшөөрөлтэйгээр ЕБС-ийн 84 дүгээр сургуулийн эмч, сурагч нарыг оролцуулан ярилцлагын асуултуудын ойлгомжтой байдал, уялдаа холбоо, нэмэх болон хасах зэргээр засч сайжруулсан. Мөн ажиглалтын шалгах хуудасны хэсгүүдийг тохиромжтой байдлаар өөрчлөн зассан.
- **Дахин нягтлалт:** Зөвшөөрлийн маягтад дурдсаны дагуу ярилцлагын үед аудио бичлэг хийсэн бөгөөд мэдээллийг оруулах болон дүн шинжилгээ хийхдээ үнэн зөв, бодитой эсэхийг аудио бичлэгтэй харьцуулан дахин шалгаж нягталсан.
- **Хөндлөнгий ажиглалт, баталгаажуулалт:** Үнэлгээний ажлын даалгаврын дагуу үнэлгээний бүх үйл явцыг НҮБ-ын Хүн амын сангийн Өсвөр үе, залуучуудын хөтөлбөрийн мэргэжилтэн удирдан чиглүүлсэн ба сургуулиудад мэдээлэл цуглуулах үйл явцад хамт оролцсон.

2.6 ҮНЭЛГЭЭНИЙ ЁС ЗҮЙ

Үнэлгээний үйл явцыг бүхэлд нь НҮБ-ын тогтолцоон дох үнэлгээний ёс зүйн удирдамж, НҮБ-ын Үнэлгээний хэм хэмжээ, стандартыг баримтлан гүйцэтгэсэн [9].

Үнэлгээний бүх оролцогчдоос бичгээр зөвшөөрөл авсан (**Хавсралт 8. Таниулсан зөвшөөрлийн хуудас**).

Зөвшөөрөл өгсөн тохиолдолд ярилцлагыг аудио бичлэгт тэмдэглэж ярилцлагад оролцогчдын нэрийг нууцлан кодлож дүн шинжилгээг хийсэн.



ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Үнэлгээ хийсэн баримт бичгийн жагсаалт:

Үнэлгээнд 30 гаруй эрх зүйн акт, бодлогын баримт бичгүүдийг судалсан. Үүнд:

- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль [5]
- Ерөнхий боловсролын тухай хууль [4]
- Хүүхэд хамгааллын тухай хууль [10]
- Дархлаажуулалтын тухай хууль [11]
- Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль [12]
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль [13]
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль [14]
- Эрүүл мэндийн тухай хууль [12,15]
- Эрүүл ахуйн тухай хууль [16]
- Хүүхдийн эрхийн тухай хууль [17]
- Vision 2050 [6]
- Засгийн газрын 2023 оны 115, 241, 478 дугаар тогтоол, [18–20]
- Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоол, [21]
- Эрүүл мэндийн яамны халдварт өвчинтэй тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө, [22]
- «Боловсролын салбарыг 2021-2030 он хүртэл хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө» [7]
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал А/220, А/475, А/812 [23]
- Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/494, А/761 дүгээр тушаал «Ерөнхий боловсролын сургуулийн эмчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар, жагсаалт батлах тухай», ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эрүүл мэндийн кабинетад байх шаардлагатай эм, хэрэгслийн жагсаалт», [24]



- Орон тооны жишиг стандарт батлах тухай Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр тушаал, [25]
- Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/609 дүгээр тушаал, [26]
- ЭМЯ-ны 2023 оны А379 «Хүн амын эрүүл мэндийн эрсдлийг харгалзан зохих ёсоор гарч буй халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам» [27].
- Эрүүл мэндийн сайдын 2012 оны А/216 дугаар тушаал, [28]
- Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/373 дугаар тушаал, [29]
- Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/527 дугаар тушаал, [30]
- Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдалд тавих ерөнхий шаардлага MNS 6782: 2019 [31]

3.1 СУРГУУЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХ ЗҮЙ, БАРИМТ БИЧГИЙН ХҮРЭЭНД ТУСГАГДСАН БАЙДАЛ

I. СУРГУУЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БА БҮРЭЛДЭХҮҮН

- “Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээ” (СЭМҮ) гэсэн нэр томъёо нь одоогоор баримт бичигт ашиглагдаагүй эсвэл тодорхойлогдоогүй байна. Харин хоёр яамны хамтарсан норм, стандарт батлах тухай тушаалд Сургуулийн эмчийг «Боловсролын бусад ажилтан» гэсэн нэрээр тодорхойлсон байна.
- СЭМҮ-нд сургуулийн эмч, сургуулийн сэтгэл зүйч, хоол зүйч, эрүүл мэндийн боловсролын багш, үйлчилгээний ажилтан зэрэг төрөл бүрийн мэргэжлийн хүмүүс багтдаг ба зарим тохиолдолд шууд бусаар хувь нэмэр оруулдаг нийгмийн ажилтан, захирал, няравууд багтана.



Үр дүн 1. Сургуулийн эрүүл мэндийн үзэл баримтлалын тухайд



Зураг 3. СЭМҮ-н эрх зүйн орчин

II. СУРГУУЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ЭРХ ЗҮЙ, ШИНЭЧЛЭЛТ

Хүснэгт 5. Хууль тогтоомжийн онцлог

Хууль эрх зүйн орчин дахь үндсэн асуултууд	Одоогийн СЭМҮ-ний төлөв	Боломжит нөлөөлөл
1. СЭМҮ тухай ойлголтыг үндэсний хууль тогтоомжид хэрхэн тодорхойлж, нэгтгэсэн бэ?	“Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээ” (СЭМҮ) гэсэн нэр томъёо нь одоогоор баримт бичигт ашиглагдаагүй, тодорхойлогдоогүй байна. Харин СЭМҮ-ний үзэл баримтлалтай холбоотой 11 хууль, 10 гаруй сайдын тушаал, стандарт, төлөвлөгөө байна.	Боловсрол, эрүүл мэндийн салбарын уялдаа бүхий сургуулийн эрүүл мэндийн нэгдсэн бодлого байхгүй байна. Үндсэн ойлголт, тодорхойлолт дутмаг байгаа нь сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээг уялдаа холбоогүйг харуулж байна.
2. СЭМҮ-ний үндсэн бүрэлдэхүүн хэсэг/ агуулга юу вэ?	СЭМҮ нь сургуулийн эмч, сургуулийн сэтгэл зүйч, хоолны эрүүл ахуйч, эрүүл мэндийн боловсролын багш, үйлчилгээний ажилтнууд зэрэг янз бүрийн мэргэжилтнүүдийг багтаасан бөгөөд зарим тохиолдолд нийгмийн ажилтан, захирал, няравууд шууд бусаар хувь нэмэр оруулдаг байна.	СЭМҮ-д хамаарал бүхий мэргэжилтнүүдийн үүрэг, хариуцлагын зөрүүтэй Өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах ажлыг голчлон үдийн цайны хөтөлбөр, ариун цэврийн байгууламж гэж ойлгож байна. Гэр бүл, олон нийттэй хамтын ажиллагаа хязгаарлагдмал байна



<p>3. СЭМҮ сүүлийн үеийн хууль тогтоомжийн шинэчлэл, өнөөгийн практикт хэрхэн нөлөөлж байна вэ?</p>	<p>Монгол Улсын Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын ерөнхий шаардлагын 2019 оны стандарт (MNS 6782:2019) нь өмнөх удирдамжаас ихээхэн ахиц дэвшил гаргаж, тусгай зориулалтын эмчийн өрөө, эрүүл мэндийн хяналтын сайжруулсан хэрэгсэл зэрэг чухал сайжруулалтыг нэвтрүүлсэн.</p> <p>Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд албан тушаал харгалзахгүйгээр бүх ажилтан сурагчдад учирч болох эрсдэлийг бууруулах, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, сургуулийн удирдлага болон бусад ажилтны хяналтын чиг үүргийг дэмжих үүрэг хүлээсэн томоохон үүргийг хэрэгжүүлж байна. 28.10. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлэх, сурагчдыг тодорхой насанд нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг холбогдох хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлэх. Эрх бүхий этгээдийг нутаг дэвсгэрт зохион байгуулна;</p> <p>Ерөнхий боловсролын тухай хууль 14.3: Ерөнхий боловсролын сургууль нь захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, багш, сэтгэл зүйч, эмч, номын санч, бусад ажилтантай байна.</p> <p>Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль 11.10. Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нь хуулийн дагуу хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, боловсролын байгууллагад ажиллаж болно.</p>	<p>Хэдийгээр эдгээр хууль тогтоомжийн шинэчлэл нь хийгдсэн хэдий ч цаашид хэрэгжүүлэх шаардлагатай байна.</p> <p>Тандалт хийх, мэдээлэх, шилжүүлэх журам байхгүй байна</p> <p>Сэтгэл зүйн зөвлөгөө авахын тулд эцэг эхийн зөвшөөрөл авах шаардлагатай байгаа нь ихээхэн бэрхшээл болж байж болзошгүй.</p> <p>Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухааны яамны 2018 оны А/024/11 тоот тушаал, ялангуяа орон тооны стандарттай холбоотой асуудал нь зарим сургуульд эмчийн хомсдолд хүргэж байна.</p>
---	---	---



<p>4. Одоогийн байдлаар ямар эрх зүйн зохицуулалт, стандарт, удирдамжууд СЭМҮ бүрдүүлж байна вэ?</p>	<p>Хууль (11)</p> <p>Засгийн газрын 2022 оны 489, 2023 оны 115, 241, 478 дугаар тогтоолууд</p> <p>Сайдын тушаал (9)</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/220, А/475, А/812, <input type="checkbox"/> Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/494, А/761 дүгээр тушаал <input type="checkbox"/> Орон тооны жишиг стандарт батлах тухай Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр тушаал, <input type="checkbox"/> Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/609 тоот тушаал <input type="checkbox"/> Эрүүл мэндийн яамны халдварт өвчинтэй тэмцэх үйл ажиллагааны хөтөлбөр, <input type="checkbox"/> Эрүүл мэндийн сайдын А379, 2023 он <input type="checkbox"/> Эрүүл мэндийн сайдын 2012 оны А/216 дугаар тушаал, <input type="checkbox"/> Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/373 дугаар тушаал, <input type="checkbox"/> Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/527 дугаар тушаал <input type="checkbox"/> Стратеги төлөвлөгөө <p>Үндэсний стандарт</p>	<p>Шинэчлэгдсэн хуулиудын дагуу заавар, журам гараагүй</p> <p>Зарим удирдамж, дүрэм журам нь сургуулийн нөхцөл байдалд уян хатан биш байх</p> <p>Санхүүгийн механизм тодорхойгүй, зохицуулалтгүй</p>
<p>5. Эрүүл мэнд, боловсролын салбарын өнөөгийн бодлого, төлөвлөгөө, стратегид СЭМҮ-ний асуудал, тэргүүлэх чиглэлүүд хэрхэн тусгагдсан бэ?</p>	<p>Ерөнхий боловсролын сургуульд бүх сурагчид, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамруулна.</p> <p>ЕБС-ийн эрүүл ахуйн хяналтын нөхцөл /Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу зургаан бүлэгт 77 шалгуур үзүүлэлт/</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Эрүүл мэндийн сургалт <input type="checkbox"/> Эрүүл мэндийн үзлэг <input type="checkbox"/> Зөвлөгөө өгөх <input type="checkbox"/> Үдийн цай <p>Өсвөр насныхны эрүүл мэндийн лавлагаа</p>	<p>Сургуулийн эрүүл мэндийн талаар бодлого байхгүй</p> <p>Хүний нөөцийн бодлого</p> <p>Нөөц, хэрэглэгдэхүүн</p> <p>Өвчний хяналтын тогтолцоо</p>



<p>6. Хууль тогтоомж, стандартад СЭМҮ-ний үндсэн нөөцийг тусгасан уу?</p>	<p>Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд 0-18 насны хүүхдүүд эрүүл мэндийн даатгалд хамрагдах хүн амын бүлэгт сургуулийн насны бүх хүүхдийг хамруулсан</p> <p>Хүний нөөц (эмч, сэтгэл судлаач гэх мэт)</p> <p>Эмчийн өрөө, тоног төхөөрөмж</p>	<p>СЭМҮ-ийн үйлчилгээнд санхүүжилт байхгүй</p> <p>засвар тусгайлсан</p>
<p>7. СЭМҮ-г гүйцэтгэхэд сургууль болон бусад талууд ямар үүрэг, хариуцлага хүлээдэг вэ?</p>	<p>Цахим хяналт, тандалт</p> <p>Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлт нөхцлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар эцэг эх, асран хамгаалагчийн үүргийг тодорхойлсон.</p> <p>Орон нутгийн засаг захиргаа</p>	<p>Сургуулийн хангаагүй хариуцлага хүлээхгүй</p> <p>стандарт тохиолдолд</p> <p>СЭМҮ-ийн мэдлэг, хамтын хязгаарлагдмал</p> <p>талаархи ажиллагаа</p>

Хүний нөөцийн тухайд

- ЭМС-ийн 2012 оны тушаал бүхий **Сургууль, хүүхдийн байгууллагад цочмог халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээний удирдамжид** Мэргэжлийн их эмчийг сургуульд ажилуулна гэж заасан. Сургуулийн өмнөх болон Ерөнхий Боловсролын Тухай Хуульд мөн сургууль эмчтэй байна гэсэн заалт орсон хэдий ч 2018 оны БСШУСС, СС-н А/024/11 тушаалд 481-с доош хүүхэдтэй сургуулиуд эмчгүй, 481-1501 хүүхэдтэй сургуульд 1 эмч, 1502 дээш хүүхэдтэй сургуульд мөн л 1 эмч ажилуулна гэж заасан. Дээрх 2 яамны хамтарсан тушаалд их эмч гэж тусгайлан заагаагүй төдийгүй хүүхдийн тоонд харгалзуулан эмч ажилуулж төсвийн хэмнэлттэй зарчмаар ажиллахыг онцолсон байна.
- Засгийн газрын 2023 оны 115 дугаар тогтоолоор баталсан **“Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл батлах тухай”** тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлд сургуулийн эмч, эмч багтаагүй бөгөөд ЕБС-ийн багшийн тэргүүлэх чиглэлд математик, мэдээлэлзүй, хими, физик, газарзүй, хөгжим гэх мэт 9 мэргэжлийг оруулжээ [20].
- Харин 2024 оны Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуульд **“боловсролын байгууллагад нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнийг ажилуулж болно”** гэж заасан нь сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээний хэрэгжилтийг хангах, өргөжүүлэхэд түлхэц болох боломжтой юм [12].



Үүрэг, хариуцлага

2018 оны ЭМС, БСШУСС-ын А/494, А/761 тоот тушаал “Ерөнхий боловсролын сургуулийн эмчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар, ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчийн ажлыг байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар” баталсан нь эмчийн өдөр тутмын ажлын чиг үүргийг тодорхойлсон үндсэн бичиг баримт болон ашиглагдаж байна. Тус тодорхойлолтод 2 үндсэн чиг үүргийн хүрээнд 21 төрлийн үйл ажиллагааг багтаасан бөгөөд урьдчилан сэргийлэх үзлэг, эмнэлгийн анхан шатны тусламж, дархлаажуулалт, мэдээлэл сургалт сурталчилгаа, ариун цэвэр, халдваргүйтгэлийн хяналт, багш ажилчдын эрүүл мэндийг дэмжих зэрэг үндсэн хэсгүүдэд багцалж болохоор байна[24].

Эдийн засгийн байдал ба хүний нөөц:

Дээрх тушаалд сургуулийн эмчийн цалинг “засгийн газрын тогтоолд зааснаар” гэсэн бөгөөд ТҮЭМ-5 бол 1,273,000, ТҮБД-5 бол 1,404,000, ТҮ-5 бол 912,000 гэж 2023 онд шинэчлэгдсэн засгийн газрын **“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”** 241 дүгээр тушаалын 6, 7,10 дах хавсралтуудад заасан [24].

Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолоор **“Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”**-г батлан 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөхөөр заасан бөгөөд тус тогтоолд ЕБС-д ажиллаж буй биеийн тамирын багш, дасгалжуулагчаас эхлэн бага, дунд, ахлах ангийн багш нар үндсэн цалингийн 8-15% -тай тэнцэх хэмжээний нэмэгдлийг олгохоор заажээ. Харамсалтай нь тус ангилалд **сургуулийн эмчийг** (сэтгэлзүйч, хоол зүйч зэрэг эрүүл мэндтэй холбогдох үүрэг, чиглэл бүхий мэргэжилтэн) **оруулаагүй** байна. Харин аймаг, сумын **эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй тохиолдолд** Эмч гэсэн ангилалаар нэмэлтийг авах боломжтой байна. [31]

Сургуулийн орчин, эмчийн өрөө, биет нөөцийн тухайд

ЭМС, БСШУСС-ын 2018 оны А/494, А/761 тоот тушаал “Үлгэрчилсэн загвар, жагсаалт батлах тухай” Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эрүүл мэндийн кабинетэд байх шаардлагатай эм, багаж хэрэгслийн жагсаалт”-р шаардлагатай биет нөөцийг тусган улмаар сургуулийн орчинд мөрдөгдөж байна [24].

Харин 2019 оны Монгол Улсын Стандарт буюу Ерөнхий боловсролын



сургуулийн орчны аюулгүй байдал ерөнхий шаардлага MNS 6782 2019-н 6.15-д эмчийн өрөөний тухай тусгайлан оруулсан байна. Эмчийн үзлэгийн өрөө, тусгаарлах өрөө, угаагууртай, бие засах өрөөнд ойр, яаралтай эм, хэрэгсэлтэй байхаас гадна сурагчийн эрүүл мэндийн карт, карт хадаглах шүүгээ болон нийгмийн эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны багцыг нэмж дурдсанаараа онцлог, дэвшилттэй стандарт гарсан байна [31].

Санхүүжилт, даатгалын тухайд

Эрүүл Мэндийн Даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйл буюу Эрүүл мэндийн даатгалд хамрагдах хүн амын бүлэгт 0-18 нас хүртэлх хүүхдийг багтаасан нь **сургуулийн сурагчдыг оролцуулсан гэж тооцохоор** байна. Харин эрүүл мэндийг дэмжихтэй холбогдох дэд бүтэц, төвийн зардлыг боловсролын, эрүүл мэндийн, барилга, зам, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран санхүүжүүлнэ гэж Боловсролын Ерөнхий Хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тус бүр заасан [13,14].

III. СУРГУУЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТ

Сургуулийн эрүүл мэндийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын тухайд

ЭМС, БСШУСС-ын 2018 оны А/494, А/761 тоот хамтарсан тушаал “Ерөнхий боловсролын сургуулийн эмч болон сэтгэл зүйчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг баталсан бөгөөд эмчтэй ЕБС-иуд тус тодорхойлолтыг баримталж байна. Мөн тухайн аймаг, сум, дүүргийн засаг даргын үүрэг оролцоо өндөр байхаар Эрүүл Ахуйн Тухай Хууль 15.1, Нийгмийн Эрүүл Мэндийн Тусламж, Үйлчилгээний Тухай хуулийн 10.1.2 -10.1.5-д тус тус заасан байна. Мөн 2023 оны Сургуулийн өмнөх болон Ерөнхий Боловсролын Тухай Хуулийн 28.10-д Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим бүртгэлийн сан бүрдүүлэх, холбогдох хуульд заасан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд суралцагчийг тодорхой насны давтамжтай хамруулах үйл ажиллагааг эрх бүхий этгээдийн баталсан журмын дагуу харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулна гэжээ [5,12,16].

Мөн Хүүхэд хамгааллын хуульд эрүүл мэндтэй холбогдох заалтуудыг тусгаж, Эрүүл Мэндийн Тухай хуульд сурагчдад харьяалал харгалзахгүй



эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, Халдварт болон Халдварт бус өвчний үндэсний төлөвлөгөө, журамд хүүхдийг эрүүл мэндийн үзлэг оношлогоо (насны дагуу), вакцинжуулалтад оруулахаар төлөвлөсөн. Гэхдээ дээрх заалтуудад эрүүл мэндийн байгууллага гэж заасан тул сургуулийн орчинд төдийлэн хамаарахгүй байна [10].

“Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудас” -н дагуу эрсдэлтэй гарсан сургуулиудад төлөвлөгөөт, санал гомдлын дагуу төлөвлөгөөт бус хяналтыг хийдэг байна [16]. Тус хяналтаар 6 бүлэг 77 шалгуураар үнэлдэг бөгөөд сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамаарах **V бүлэгт Хүүхдийн эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх арга хэмжээ**-нд Эрүүл мэндийн тухай хуулийн 25.1, Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага MNS 6799:2019 стандарт, Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал MNS 6782:2019 стандарт болон ЭМС-ын 2014 оны А/340 тоот тушаалын 2-р хавсралт «Ажил мэргэжлээс хамааран эрүүл мэндийн үзлэг хийх жагсаалтын 12, БШУС-ын 2022 оны А/259 тушаалуудын хэрэгжилтийг шалгах 13 үзүүлэлттэй байна[32,33].

Улмаар зөрчлийг арилгах хугацаат үүрэг, даалгаврыг өгч шаардлагыг хүргүүлэн ажилладаг байна.

Үйлчилгээний бэлэн байдлын тухайд

Боловсролын багц хуулиудад сургуулийн орчин нөхцлийг зааж оруулсан төдийгүй ЭМС, БСШУСС-ын 2018 оны А/494, А/761 тоот тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн эмчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар, ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчийн ажлыг байрны тодорхойлолтын үлгэрчилсэн баталсан нь эмчийн үзүүлэх үйлчилгээний бэлэн байдлыг хууль эрхзүйн хувьд хангасан гэж үзэж болохоор байна. Харин Эрүүл Мэндийн Тухай Хуулийн 39 дүгээр зүйлд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авна, Эмчийн ажлын байрны тодорхойлолтод Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн нас, бие бялдар, сэтгэлзүйн онцлогт тохирсон хөдөлгөөн болон сэргээн засах эмчилгээ, тусламжийг холбогдох эрүүл мэндийн мэргэжлийн байгууллага, эмч, мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулах гэж заасан байна. Ингэж тусгайлан оруулснаар **сурагчдыг тэгш хамруулах, хөгжлийн бэрхшээлээс үл шалтгаалан ЕБС-д суралцахыг дэмжсэн, хүртээмжтэй байдалд эерэг нөлөө үзүүлэх боломжтой эрхзүйн орчин үүссэн байна.**



Үйлчилгээний чанарын тухайд

Боловсролын Ерөнхий Хуулийн 30.1-д Аймаг, нийслэлийн Засаг дарга **сургуулийн үйлчилгээний чанар, үр дүнг хариуцахаар** тусгасан бөгөөд тусгайлан эрүүл мэндийн асуудал, үйлчилгээ гэж дурдаагүй байна [4]. Мөн үнэлгээнд хамруулсан Эрүүл мэндийн холбогдох хууль, тогтоомж, баримт бичгүүдэд сургуулийн орчин дах эрүүл мэндийн үйлчилгээний чанарын асуудал дурдагдаагүй байна.

Эмчийн ажлын байрны тодорхойлолтод үйлчилгээний чанар, аюулгүй байдалтай холбогдох заалтууд тусгагдаагүй байна.

Эрүүл мэндийг дэмжих, сурталчлах тухайд

Эрүүл Ахуйн Тухай Хуулийн 15 дугаар зүйлд Эрүүл ахуйн сургалтыг ЕБС хариуцахаар, БСШУС-ын сайдын 2018 оны А/467 дугаар тушаалаар IY-XII ангид “Эрүүл мэнд” хичээлийн хөтөлбөр хэрэгжснээр эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих, сурталчлах үйл ажиллагаа сургуулиудад хэрэгжиж буй юм [34]

ЭМС-ийн 2022 оны А/609 Стратеги төлөвлөгөөнд Бүх шатны боловсролын байгууллагын эрүүл мэндийн хичээл заах багш нарт зориулж контентийг боловсруулж байршуулах, 0-19 насны залуучуудын осол гэмтлийн шалтгаант өвчлөл, гэмтлийг бууруулах зэрэг зорилтот заалтууд тусгагдсан нь эрүүл мэндийн салбарын оролцоог Боловсролын байгууллагын үйл ажиллагаатай уялдуулсан тодорхойлсоноороо онцлог байна[20] .

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний 2024 оны 1 сард батлагдсан шинэхэн хуульд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд 3 заалтаар тодорхой тусгажээ [12].

Тандалтийн тухайд

Сургуулийн өмнөх болон Ерөнхий Боловсролын Тухай Хуулийн 28 дугаар зүйл буюу Нутгийн удирдлагын үүрэг, хариуцлагад ЕБС-ийн суралцагчийн эрүүл мэндийн хяналт, үзлэг, оношлогоо зэрэг өргөн хүрээнд тусгаснаараа онцлог байна.

Харин ЭМС-ын 2022 оны А/373 тушаал, ЭМС-ын 2018 оны А/527 тушаалд заасны дагуу Сургуульд ирцийн бүртгэлийн тандалт хийх, тандалтад ашиглах боломжтой тархвар судалгааны хуудсуудыг оруулсан байна [29,30]. Энэхүү арга нь сурагчдын дунд халдварт ба халдварт бус өвчний асуудлуудыг тодорхойлж, хариу арга хэмжээ



авахад хэрэгтэй заалт юм.

Сургуулийн өмнөх болон Ерөнхий Боловсролын Тухай Хууль 17 дугаар зүйл буюу Удирдах болон бусад ажилтны үүрэгт суралцагчийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих ажлыг албан тушаалын ялгаагүй бүх ажилтнуудын үүрэг болгон заасан нь чухал заалт болсон байна [5].

Хамтын ажиллагааны хүрээнд

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлд Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд олон талт шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хяналт тавихаар заасан, **Сургуулийн өмнөх болон Ерөнхий Боловсролын Тухай Хуулийн шинэчилсэн найруулгад** нутгийн өөрөө удирдах байгууллага болон захиргааны байгууллагын үүрэг, оролцоог тусгайлан оруулж зохион байгуулалтыг хариуцуулсан зэрэг нь орон нутгийн удирдлагын үүрэг оролцоог сургуулийн үйл ажиллагааны тухайд өндөр түвшинд авчирсан байна. Харин **Хүүхэд Хамгааллын Тухай хууль** 15 дугаар зүйлийн 15.1.5.эцэг, эх, гэр бүлийн гишүүд, үе тэнгийхэн, сургууль, хамт олонд нь зөвлөгөө өгөх, тогтмол хугацаанд уулзалт, ярилцлага зохион байгуулж, үр дүнг тооцох; 15.1.6.хорт зуршлаас ангижрах эмчилгээнд хамруулах, зөвлөгөө өгөх, ажил, сургууль, мэргэжил олгох сургалтад хамруулах зэргээр Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хамтарсан багийн ажил үйлчилгээнд сургуулийн орчин дах эрхийг оруулсан байна [10]. **Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн** 42.1.2.дэд бүтэц, нийтийн зориулалттай барилга байгууламж, хэвлэл, мэдээллийн хэрэгслийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах, хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол, эрүүл мэнд, биеийн тамир, спорт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шат дараалсан арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих гэж заасан нь сургуулийн орчинг тусгайлан заагаагүй ч нийтийн зориулалттай барилга, байгууламж, дэд бүтэц гэдэг утгаараа сургуулийн орчинг хамаатуулж болохоор байна.

Эцэг, эх, асран хамгаалагчдын үүрэг, оролцооны тухайд

Боловсролын Тухай Ерөнхий Хуулийн 10.1.10-д зааснаар Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон суралцагчийн зөвшөөрөлгүй эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, сорилд хамрагдахгүй байх; 40.2.7-д Хүүхдийнхээ хөгжил, төлөвшил, эрүүл мэнд, аюулгүй байдалд байнгын анхаарал тавих, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичиг, дүрэмт хувцсаар хангах зэргийг тусгасан



[4]. Харин 10-р заалтад дурдсаны дагуу **эцэг, эхийн зөвшөөрөлгүй сэтгэлзүйн зөвөлгөө, дэмжлэг авах боломжгүй болсон**. Улмаар тусламж үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, тусламж авах боломж хязгаарлагдах эрсдлүүд үүсч болзошгүй байна.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 10.1.3.хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах гэж эцэг, эх асран хамгаалагчийн үүргийг ерөнхий тусгасан байна [17]. Үнэлгээний хүрээнд судалсан хууль, эрхзүй холбогдох баримт бичгүүдэд эцэг, эх асран хамгаалагчин үүрэг, оролцоог хэт ерөнхий, зөвшөөрөл өгөх төдийхнөөр өнгөц тусгасан нь хүүхдийнхээ эрүүл мэндэд анхаарал хайхрамжгүй хандах, сургуулийн орчин дах эрүүл мэндийн арга хэмжээ, хөтөлбөр, үйлчилгээг сонирхох, идэвх, санаачлага гаргахгүй байх зэрэг сөрөг үр дагавруудыг үүсгэх боломжтой байна.

Энэхүү хүснэгтэд ДЭМБ-аас тодорхойлсон Эрүүл мэндийг дэмжих бодлогын талаарх сургуулиудын 6 үндсэн асуудлын улс орны ялгаатай байдлыг нэгтгэн харуулав.[1]

WHO удирдамж	Монгол	Дутагдалтай тал
Сургуулийн бодлого (жишээ нь, манлайлал, байгууллагын чадавхи)	Салангид, хэсэгчилсэн холбогдох хууль тогтоомжийн хүрээ байна.	СЭМҮ-ний талаар тусгайлсан бодлого, удирдамж байхгүй
Орчин (жишээ нь: аюулгүй тоглоомын талбай, аюулгүй цэвэр хүйсийн бие засах газар)	Сургуулиуд нь газарзүйн байршил, өмчлөл болон # сурагчдаас хамаарч өөр өөр байдаг	Хүрээлэн буй орчны стандарт сул Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой стандартууд нь сургуулийн бодит болон тодорхой нөхцөл байдалд илүү эрч хүчтэй, хариу үйлдэл үзүүлэх боломжтой.
Нийгмийн орчин (жишээ нь, өмч)	Хууль тогтоомжийн хүрээнд нийгмийн орчны асуудлыг хэсэгчлэн тусгасан	Тодорхой заавар, санхүүжилт байхгүй
Эрүүл мэндийн ур чадвар, боловсрол/ сургалтын хөтөлбөр	Эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөр нь 6-12-р ангийнханд зориулагдсан	Зан үйлийн өөрчлөлт нь хязгаарлагдмал; иж бүрэн, шинэлэг арга барил хэрэгтэй



Эцэг эх, олон нийттэй харилцах (жишээлбэл, олон нийтийн оролцооны механизм)	Хууль, заалтууд нь ерөнхийдөө сургуулийн орчинтой холбоотой байдаггүй	Эцэг эхийн эрүүл мэндийн боловсрол, оролцоо нь зохион байгуулалтгүй байна
СЭМҮ-д хамтрах (жишээ нь өрхийн эрүүл мэндийн төвтэй холбогдох)	Ихэвчлэн ӨЭМТ, бусад эмнэлэгүүдэд ханддаг	Хяналт, тайлагнах систем байхгүй

Эх сурвалж: ДЭМБ-ын удирдамж 2021

3.2 СУРГУУЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН МЕХАНИЗМ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДИЙН БАЙР СУУРЬ

Ерөнхий боловсролын нийт 6 сургуулийг (Улсын, Хувийн, Улаанбаатар хотын гэр хороолол болон орон сууцны хорооллын, Аймгийн болон сумын сургууль, сурагчдын тоонд харгалзуулан төлөөллүүдийг) хамруулаа. Ерөнхий мэдээллийг харуулбал:

1. Өвөрхангай аймгийн Арвайхээр-1, нийт суралцагчдын тоо 2935,
2. Говь-Алтай аймгийн II -р сургууль, нийт суралцагчдын тоо 840,
3. Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын ЕБС, нийт суралцагчдын тоо 378,
4. Баянзүрх дүүргийн 21-р сургууль, нийт суралцагчдын тоо 4304,
5. Баянзүрх дүүргийн 79-р сургууль, нийт суралцагчдын тоо 2703,
6. Баянгол дүүргийн Эрхэт эрдэм хувийн сургууль, нийт суралцагчдын тоо 645

Сонгогдсон сургуулиудын эмчийн өрөө, өдөр тутмын үйл ажиллагаатай танилцаж ажиглалтын аргаар, БСШУЯ, ЭМЯ-ны төлөөлөл бүхий 3, сургуулийн эмч, ажилтнууд бүхий 14, эцэг эх, асран хамгаалагчдын төлөөлөл 3, сурагчдын төлөөлөл бүхий 6-12 дугаар ангийн 9 сурагчыг хамруулан ярилцлагын аргаар үнэлгээг гүйцэтгэлээ.



Зураг 1. Үнэлгээнд хамрагдсан зарим сургууль

I. УДИРДАХ БОДЛОГО, ӨНӨӨГИЙН СТРАТЕГИ

Одоогоор Боловсрол, эрүүл мэндийн салбарт сургуульд суурилсан эрүүл мэндийн талаар тодорхой бодлого байхгүй байна. Тиймээс энэ нь сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээний уялдаа холбоогүй байдал, хуваагдмал хэрэгжилтэд нөлөөлж болзошгүй юм. Сургууль бүрт эмч байх нь сурагчдын тоо, сургуулийн тодорхой нөхцөл байдлаас хамааран хувьсах боломжтой.

II. БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХ СУРГУУЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургуульд суурилсан эрүүл мэндийн тусгайлсан бодлого Боловсролын салбарт хараахан байхгүй байна. Сургууль бүр суралцагчдын тоо, нөхцөл байдлаас хамааран эмчтэй, эмчгүй янз бүр байна. Боловсролын Ерөнхий Газар (БЕГ) 2022 онд байгуулагдаж БШУЯ-ны тодорхойлсон бодлого чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж улмаар суралцагчдын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй болсон. БЕГ дотроо газрууд хамтрах, Багш ажилтан, байгууллагын хөгжлийн газрын Биологи, Эрүүл мэндийн багшийн хөгжил хариуцсан мэргэжилтэнтэй бэлгийн цогц хөтөлбөр, хорт зуршил, өсвөр үеийн эрүүл мэндийн ажлуудыг төлөвлөн хийдэг байна.

Харин Боловсролын салбарын зүгээс Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөн, ЭМЯ ялангуяа Нийтийн эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэжлийн болон үндэсний төвүүдтэй Үндэсний арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хамтардаг байна. Эрүүл мэндтэй холбогдох олон улсын төсөл, хөтөлбөрүүдийг НҮБ-ын Хүн Амын сан, НҮБ-ын Хүүхдийн сан, Орбис, Жайка зэрэг байгууллагуудтай Боловсролын салбараас хамтардаг боловч нэгтгэсэн том төлөвлөлт байхгүй байна.

Хөдөлмөр нийгмийн хамгаалал, цахим хөгжлийн яамдууд, Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын ерөнхий газартай Хүүхэд хамгааллын асуудлаар мөн хамтардаг ба эрүүл мэндийн асуудлууд хөндөгддөг байна. Хамтын төлөвлөгөөндөө 21 төрлийн үйл ажиллагааг багтаасан бөгөөд бага наснаас оюутан хүртэл хөгжил хамгаалал, сэтгэлзүй, орчин, эрүүл мэнд зэрэг багтаадаг байна. Эрүүл мэндийн бодлого, төлөвлөлтийг Боловсролын байгууллагад орхигдох нь цөөнгүй хэдий ч сүүлийн жилүүдэд тушаал, зааварт санал өгөх, ажлын хэсэгт оруулах зэргээр хамтын ажиллагаа сайжирч, салбар дундын хамтын ажиллагаанд түлхүү анхаарах болсныг ярилцлагын явцад онцолж байв.

Сургуулийн орчинд эрүүл мэндийн чиглэлээр гарсан ахиц, дэвшил: Эрүүл мэндийн яамнаас эмч нарын ур чадвар, үр нөлөөллийг дээшлүүлэх мэргэжлийн арга зүйгээр хангахаар ажиллаж байна. Саяхан Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль



батлагдсанаар хоол хүнс, байгаль орчин зэрэг үндсэн 8 чиглэлээр хороод, өрхүүдийг хамруулсан цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

“Эрүүл мэндийн яаманд янз бүрийн салбарын мэргэжилтнүүд хүүхдийн эрүүл мэнд, байгаль орчин, хоол хүнс, сэтгэл зүй, урьдчилан сэргийлэх зэрэг асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй ажилладаг. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн ажлыг өрхийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан явуулдаг. Эрт илрүүлэгтэй холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2024 оны хоёрдугаар сарын 24-ний өдрийн А75 тоот тушаал гарсан. Миний хувьд гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр зөвлөх багш бэлтгэхэд анхаарч байна. Охидын жирэмслэлт их байгаа тул энэ талаарх ажлууд хийгдэж байна. Мөн улсын хэмжээнд одоо хэрэгжиж байгаа 8 үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн, урт хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах үүрэг бүхий халдварт бус техникийн ажлын хэсэг байгуулахаар хэлэлцэж байна. Эрүүл мэндийн сэдвээр хичээл заахад багш нар нарийн бүтэц зохион байгуулалтаас эхлээд мэргэжлийн онол хүртэл тайлбарлахад бэрхшээлтэй байдаг бол сургуулийн эмч нар оюутнуудад заах арга зүйгүй байдаг. Саяхан Японы сургуулиудад очиж туршлага судаллаа, сургуульд хоол хийх хичээл, йог гэх мэт олон зүйлийг цогцоор нь хэрэгжүүлж байна” гэв. **(ЭМЯ-ны НЭМГ-ын Нөхөн үржихүй, залуучууд, эрэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн)**

Гэсэн хэдий ч, сургуулийн эмч нарт зориулсан нарийн, өргөн хүрээтэй сургалт дутмаг байгааг тэмдэглэж байна. Сургуулийн эмч нар боловсролын салбарт ажиллаж байгаа нь эрүүл мэндийн салбарын хангалттай сургалт, дэмжлэг үзүүлэх боломжийг хязгаарлаж магадгүй юм.

Эрүүл мэндийн үйлчилгээг сургуульд үзүүлэхэд тулгамдсан асуудал: Ерөнхий боловсролын сургуулийн захирал, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн багш нар ЭМЯ, БШУЯ-ны тушаал, зааврын дагуу ажиллаж байна. Сургуулийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний механизм, цар хүрээ, өдөр тутмын үйл ажиллагааг тодорхой болгоход сургуулийн насны хүүхдийн эрүүл мэнд, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж, эрүүл мэндийн хичээл заадаг ар гэрийнхэн, багш нартай хамтран урьдчилан сэргийлэх үзлэгийг жилд нэг удаа зохион байгуулдаг.

Гэхдээ сургуулийн нөхцөл байдлаас шалтгаалан эдгээр ажилтнууд өөр өөр байж болно. Үнэлгээнд оролцсон ажилтнууд СЭМҮ-н тодорхой үйл явц, хамтын ажиллагааг бий болгох, цаашдын санаачилгад байнгын



дэмжлэг, нөөцийг бүрдүүлэхэд анхаарлаа хандуулсан.

“Одоогоор тус сургуульд эрүүл мэндийн механизм байхгүй. БСШУСЯ-ны сэтгэл зүйч, нийгмийн ажлын албатай холбоотой заалтын дагуу үйл ажиллагаа явуулж байна. Би сэтгэл судлаачийн чиг үүрэгтэй холбоотой үндсэн ажлууд, салбар байгууллагуудын захидал, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн тухай хууль зэрэг ажил дээр голчлон ажиллаж байна.

(Сэтгэл зүйч, 32 настай, эмэгтэй)

“Идэвхтэй оролцоогүйгээс эрүүл мэндийн мэдээлэл, боловсрол дутмаг байх шиг байна. Түүнчлэн урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт явуулах, эмч нарт үзүүлэх эм тариа, тоног төхөөрөмж хүрэлцэхгүй байгаа зэрэг хүндрэлүүд байна. Хүүхдэд эмч нарын үзлэг хийх иж бүрэн эд хэрэгслээр тоноглогдсон өрөө, орчинг бүрдүүлэх шаардлагатай байна.” **(Нийгмийн ажилтан, 34 настай, эмэгтэй)**

“1 эмч хангалтгүй шүү дээ. Эрүүл мэндийн хичээлийг мэргэжлийн хүнээр, чанартай заалгах хэрэгтэй гэж бодож байна. Мөн эм тариа хүрэлцэхгүй, санхүүжилтгүй байгаа учраас энэ тал дээр анхаарч, нөөцтэй болгох хэрэгтэй. Манай сургууль 2000 гаруй хүүхэдтэй, миний хувьд өдөрт хамгийн багадаа 2 хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг. Үүнд: багш, эцэг эхтэй хэрхэн хамтран ажиллах, эрсдэлтэй бүлгийн хүүхдүүдтэй хэрхэн ажиллах асуудал ихэвчлэн тулгардаг бөгөөд шаардлагатай бол дараагийн шатны мэргэжлийн эмч рүү шилжүүлдэг. **(Сэтгэл зүйч, 34 настай, эмэгтэй)**

“Лхагва гарагийг сургууль дээр эрүүл мэндийн өдөр болгон тэмдэглэдэг. Эрүүл мэндийг дэмжих, хэвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсний дараа хяналт, шалгалт хийдэг. 2018 оноос хойш хөгжлийн төв буюу тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулсан танхимтай болсон. Тусгай хэрэгцээт 10-аас дээш хүүхэдтэй бөгөөд бид мэргэжилтэн, эмч нарын үзлэгийг сургуулд хуваарийн дагуу хийдэг **(Газар зүй, эрүүл мэндийн багш, 45 настай, эмэгтэй)**

Сүүлийн үед сургуульд цахим ажил их өрнөж байна. Эрүүл мэнд-газарзүйн хичээлийн хөтөлбөрт ороход энэ нь хэвийн, ямар ч асуудалгүй. Би өөрөө зохицуулж чадна. **(газар зүй, эрүүл мэндийн багш, 29 настай, эмэгтэй)**

“Өөрчлөлттэй нийлдэггүй, эмч, сэтгэл зүйчгүй сургууль байдаг юм шиг байна. Сургууль нь эмчтэй байх ёстой. Эрүүл мэндийн багт хүүхдийн нөлөө үзүүлэх хүчтэй байдаг. Эрүүл мэндийн баг нь үе тэнгийнхэндээ зөв үлгэр дуурайл үзүүлснээр жинхэнэ нөлөөлөгч байж чадна. Манай аймагт тусгай эмч байдаг. Үе тэнгийнхэндээ зөв үлгэр дуурайлал үзүүлэх



замаар өсвөр үеийнхний кабинет 2022 онд Бүсийн эрүүл мэндийн оношилгоо эмчилгээний төвд нүүж, мэргэшсэн эмч нартай, мэргэшсэн сувилагчтай болсон нь томоохон өөрчлөлт юм.” (Сэтгэл зүйч, 34 настай эмэгтэй)

Эрүүл мэндийн багш нар ихэвчлэн газарзүй, биологи, биеийн тамирын дасгал зэрэг хичээлүүдийн аль нэгийг эрүүл мэндийн хичээлийн хамт заадаг. Тэд сурах бичгийн дагуу хичээл заадаг бөгөөд сурагчид эрүүл мэндийн талаар дэлгэрэнгүй асуулт асуухад мэргэжилтэн, эмчид хандахыг зөвлөж байна. Багш нарын ачаалал хэвийн, эрүүл мэндийн хичээлийг хичээлийн жилийн эхэнд анги бүлгүүдэд сургалтын хөтөлбөрийн дагуу орохоор аль хэдийн төлөвлөсөн байсан.

Хүүхдийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хүүхэд хамгааллын багийн гишүүд ажиллаж, тусламж хүссэн сурагчдад сэтгэл зүйчид сэтгэл зүйн зөвлөгөөг өгдөг. Сэтгэл зүйчид улирал эсвэл жилд нэг удаа бүлгийн зөвлөгөө эсвэл сэтгэл зүйн сургалт, мэдээлэл хийдэг.

Нийгмийн ажилтнууд шаардлагатай үед сурагчид болон эцэг эхчүүдэд зөвлөгөө өгөх зорилгоор сургуулийн эмч нартай шууд бусаар хамтран ажилладаг. Мөн тэд Хүүхэд хамгааллын багийн гишүүнээр ажилладаг.

Сургуулын эмч нарын өдөр тутмын үүрэг, ажлын орчин нөхцөл

Ажлын байрны тодорхойлолтын дагуу жилийн төлөвлөгөөг гарган сургуулийн захирлаараа батлуулан ажилладаг байна.

- Сурагчдад чиглэн Урьдчилан сэргийлэх үзлэг, дархлаажуулалтад хамруулах, зовиурын улмаас ирсэн сурагчдад үзлэг хийх, зарим тохиолдолд эм өгөх, акт бичих, өрх, дүүргийн эмчид илгээх, эцэг эхийг дуудан хүлээлгэж өгөх, дотуур байранд дуудагдан үзлэг хийх;
- Сургуулийн багш, ажилтнуудад чиглэн үзлэг хийх, даралт үзэх, дусал хийх, Эрүүл мэндийн багшийг завгүй, эзгүй үеэр хичээл орох, хүүхэд хамгааллын багт ажиллах;
- Харин сургуулийн орчинд анги танхим, ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ шалгах, гадна орчны тохижилт, цэвэрлэгээ хариуцах, гэрээт ариутгал халдваргүйтгэл хийлгэх, зарим шаардлагатай нөхцөлд өөрөө хийх, үдийн хоолны цэс зохиох, технологийн зарт бэлтгэх, эрүүл ахуйг шалгах зэрэг үйл ажиллагааг өдөр тутам, байршил, өмчийн хэлбэр үл харгалзан нийтлэг гүйцэтгэдэг байна.

“Ажлын байрны тодорхойлолтод заасан ажлуудаа хийдэг, хууль эрхзүйн мэдээлэл муу. Тэр бүр сургалтад ороод байх боломж бага. Өглөө ирэхэд хоол, цайгүй хүүхдүүд хүлээж байдаг. Миний ажлын цаг 09:00-



18:00, заримдаа 21 цаг хүртэл цэвэрлэгээ шалгаж явдаг...”**(Аймгийн сургуулийн эмч, 52 настай, эмэгтэй)**

“Хааяа фэйсбүүкээс ороод тушаал шийдвэрээ харчихдаг. Хүүхдүүдээ өвдвөл үзээд 2-3 хоног акт өгдөг, эрүүл ахуй, ариутгал цэвэрлэгээг хариуцан шалгана. Үдийн цайны цэс гаргадаг. Хавар, намартаа үзлэг хийх, 7 болон 15 насанд сахуу, татран, 6, 7 насныханд Улаанбурханы нэмэлт дархлаажуулалт хийсэн. Дотуур байрны хүүхдүүд өвдвөл үзнэ, дуудагдана. Мөн 62 багш, ажилтнуудаа үзнэ, зөвөлгөө өгөх ажил хийдэг.” **(Сумын сургуулийн эмч, 38 настай, эмэгтэй)**

“Өрх болон дүүргийн ЭМТ-тэй хамтран ажилладаг бөгөөд томуу, улирлын дархлаажуулалт, товлолын дархлаажуулалт, урьдчилан сэргийлэх үзлэг хийх зэрэг хамтын ажиллагааг тогтмол хийдэг тул өдөр тутмын ажилтай холбогддог. Сургуулийн хүүхдүүдэд ЭМ-ийн боловсрол олгох зөвлөгөө өгөх, байнгын асаргаатай сурагчдад гэрээр очиж зөвлөгөө өгдөг.” **(УБ хотын гэр хорооллын сургуулийн эмч, 31 настай, эмэгтэй)**

Эдгээр олон төрлийн өдөр тутмын үүрэг нь СЭМҮ-ийн үндсэн бүрэлдэхүүний хэсэг бөгөөд СЭМҮ-ийн үзэл баримтлалтай маш сайн нийцдэг боловч зөвхөн 1 эмч үүнийг бие даан биелүүлэх нь бараг боломжгүй юм.

Өдөр тутмын олон ажил зэрэг хийх завгүй хуваарийн улмаас сурагчдын эрүүл мэндийг нэн тэргүүнд тавих нь бусад үйл ажиллагаагаар солигдож байгаа нь харагдаж байна. Сургуулиас тавьж буй шаардлага, менежерүүдийн сургуулийн эмч нарын үүргийн талаарх ойлголт нь сургуулийн эмч нарын эрүүл ахуй, хоол тэжээлийн чиглэлээр үзүүлэх үйлчилгээнд нөлөөлж болзошгүй. Цаашилбал, хүүхдийн тоо их, сургууль тусдаа хоол зүйч, сэтгэл зүйч байхгүйгээс ачаалал нэмэгддэг. Тиймээс зарим сургуулийн эмч нарын хэт ачаалал нь бусад үүрэг хариуцлагаа биелүүлэхийн зэрэгцээ сурагчдын эрүүл мэнд, үйлчилгээний чанарт анхаарлаа хандуулахад саад учруулж болзошгүй юм.

“Эмчийн орон тоог хүүхдийн тоо, ажлын ачаалалд тооцох хэрэгтэй. Эмчлэх, сувилах гээд тусдаа, эмч тариа хийх ёсгүй. Эрүүл мэндийн багаараа ажиллах хэрэгтэй байдаг. 4304 хүүхдэд 1 эмчтэй, цэвэрлэгээ үйлчилгээ, үдийн хоолны эрүүл ахуйн хяналт хийхээр явсан үед үзлэг хийх боломжгүй болдог. Уг нь 2 эмчтэй байсан, саяхан 1 эмчтэй байх ёстой гээд тэтгэвэрт гарсан эмчийг ажлаас чөлөөлсөн. Бас 1 сэтгэлзүйчтэй байсан, гарсан гэсэн, яагаад гарсныг мэдэхгүй. Ажил нь



их, хэцүү байсан байх” (**УБ хотын орон сууц хорооллын сургуулийн эмч, 53 настай, эмэгтэй**)

“Улсын сургуульд эмч нарыг гаргуунд нь хаясан, багш нар л чухал байдаг. Дэмжлэг, урамшуулал, шагнал гээд бүх зүйлд хаягддаг. Боловсролын яамнаас зөвхөн сургалтад л анхаардаг. Эмч нарын ахуй байдал, ажиллах орчин, нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй л санагддаг. 1000 хүүхдэд 1 эмч байх зэргээр..Манайх амны хөндийн эрүүлжилттэй сургууль болохоор зориж байна. Ажлын ачаалал ч бага тул 14-16 цагийн хооронд бүлгүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох, хичээл заах ажлаа хийдэг. Эмч мэргэжилтэй эцэг, эхчүүдтэй хамтраад ажилладаг, их давгүй байдаг шүү.” (**УБ хотын хувийн сургуулийн эмч, 53 настай, эмэгтэй**)

Өсвөр үеийн кабенитийн эмч: Дүүргийн өсвөр үеийн кабенитын эмч нар сургуулийн эмчийн илгээсэн хүүхдийн үзлэг оношилгоог хийх, шинжилгээ төлөвлөх, дараагийн шатлалд шилжүүлэх үйл ажиллагааг өдөр тутам хийдэг байна. НҮБ-ын Хүн Амын сангийн санхүүжилтээр 2011 онд Өсвөр үеийн кабинет нэршлээр ажиллаж эхэлсэн байна. Мөн Сургуулийн эмч нарт зориулан сургалт, мэдээллийг тулгамдсан сэдвийн хүрээнд зохион байгуулдаг. Сонгогдсон дүүргийн тухайд улсын өмчийн 17, хувийн өмчийн 8 нийт 25 орчим ЕБС-тай нийт 23800 сурагч байна. Тус кабенитын эмч өөрийн ажлын ачаалал, онцлогт багийн ажиллагаа чухал, сувилагч, нийгмийн ажилтан хамтран ажиллах чухал гэдгийг дараах байдлаар онцолсон.

“Миний тухайд өдөр тутамдаа ЭМС-ийн А399 голчлон барина. Мөн А97-г баримтлан эх нялхас руу үзсэн хүүхдээ шивэх, А364 охидын үзлэг хийхэд баримталдаг. Хүчирхийллийн тохилдол бол А351 гэх мэт өөр өөр тушаал баримтлана. Ганцаараа ажилладаг, сувилагчгүй. 0-5 насны хүүхдийн эмчгүй газрууд эмч нар нь өсвөр үеэ хавсраад хийдэг.

Ихэвчлэн хоолойны ангины, бөөр, уушигны өвчлөл, охидын биений юмны алдагдал, мэдрэлийн ядаргаа, охидын цус алдалт, ходоодны шархлаа зэрэг насанд хүрэгчдийн өвчлөл нэмэгдэх хандлагатай байна. Сэтгэцийн тулгамдсан асуудлууд болох гараа зүссэн гэх мэт хүүхдүүд орж ирдэг. Миний хувьд ярихад чөлөөтэй хүүхэдтэй ярилцаад, зөвлөөд явуулдаг. Зан үйлийн өөрчлөлт илэрсэн хүүхдийг харин сэтгэцийн кабенит руу илгээдэг. Бусад байгууллагуудтай хамтран сургалт хийхийн тулд эндэх ажлаа зохицуулдаг. Сургуулийн хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг хийдэг боловч хамрагдалт хангалтгүй байгаа. Сургуулийн хүүхдүүдийг ангиар нь авчраад үздэг. Нэг хүүхдийг үзэхийн тулд ангиар нь авчираарай гэдэг. Ганцаараа гэвэл хүүхэд



ирдэггүй. Өнөөдөр гэхэд 13 хүүхдийг үзэх, шинжилгээ төлөвлөх, давтан үзлэгтэйгээ нийлбэл 17 орчим үзлэг байна. Хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээтэй хүүхдүүд ирдэг. Ялгаатай зүйл байхгүй, үзүүлээд тусламж үйлчилгээгээ авна. Өсвөр насны хүүхдийн үзлэг 20-25 минутад л амждаг, хугацаа их ордогыг тэр бүр хүмүүс ойлгодоггүй.” **(Дүүргийн өсвөр үеийн кабенигийн эмч)**

Тогтвортой байдал ба нийгмийн эрүүл мэндийн санаачлага: Сургуулийудад нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа тогтвортой хэрэгжих боломжтой болж буй юм. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (НЭМҮТ)-ийн арга, хэмжээний төлөвлөгөө зэрэг холбогдох чиглэл бүрээр хүүхдэд чиглэсэн ажлууд тусгагдсан байдаг. Өрхийн эмнэлгийн гуравласан гэрээнд харьяа сургуулиудад эрүүл мэндийн нөлөөллийн ажлыг хийхээр тусгагдсан байдаг байна.

Сургалт, чадавхийг бэхжүүлэх: Эрүүл мэндийн яам нь Өсвөр үеийн кабинетын эмч нарыг мэргэжлийн сургалтад хамруулж, 10-19 настнуудад нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэхээс гадна сургуулийн эмч нарыг чадавхижуулах, сургалт явуулахад анхаарч байна. Энэ арга нь сургуулиудын эрүүл мэндийн ерөнхий тогтолцоог бэхжүүлэх зорилготой юм.

Хоол тэжээлийн асуудал, сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх нь: Сургуулийдийн хоол тэжээлтэй холбоотой томоохон асуудлуудыг харгалзан Эрүүл мэндийн яамнаас эдгээр асуудлыг шийдвэрлэх шаардлагуудыг тавьсан. Гэсэн хэдий ч сургуулийн орчин дахь эрүүл мэндийн үйлчилгээ нь боловсролын салбарт харьяалагддаг бөгөөд энэ нь Эрүүл мэндийн яамны өдөр тутмын оролцоог хязгаарладаг. Боловсролын яамнаас сурагчдын эрүүл аюулгүй байдлыг дэмжих сэтгэл судлаачдыг сургах санаачилга гаргаж байгаа бөгөөд сэтгэцийн эрүүл мэндийг анхаарч үзэж байна.

“ Сургуульд нэг л эмч байдаг, эмчийн стандарт хангадаг эсэхийг мэдэхгүй. Сандал, чагнууртай л харагддаг. Үзлэгийн өрөөтэй, хүүхдийг тайвшруулах зэрэг эмчийн өрөөг тохижуулах, өсвөр үеийхэнд мэдээлэл хүргэх боломжтой байх хэрэгтэй. Сургуулийн эмч үндсэн ажлаа л хийх болохоос биш эрүүл мэндийн боловсролыг дүүрэг, өрхийн эмнэлгээс оруулах хэрэгтэй, цаашид эмч нарыг тогтвортой ажилуулах, чадавхижуулах хэрэгтэй байна.” **(ЭМЯ-ны Нийтийн Эрүүл мэндийн газрын УСХЗХ-н Нөхөн үржихүй, залуучууд, эрэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн)**

III. СУРГУУЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДЭВШИЛ, АХИЦ

Сургуулийн хүний нөөцийг сайжруулахад эмчийг орон тооны ажилтнаар



ажиллуулах, сэтгэл зүйч бэлтгэх, боловсролын байгууллагад хоол зүйчийг ажиллуулах зэрэгт ихээхэн анхаарч байна. Эхэндээ сургуулийн эмчийн үүргийг төдийлөн онцолдоггүй байсан ч сүүлийн жилүүдэд эмчийг газар дээр нь ажиллуулахын ач тусыг ихээр хүлээн зөвшөөрөх болсон. Түүнчлэн өмнө нь түр зогсоогоод байсан “Эрүүл мэндийн боловсрол” хичээлийг сэргээн нэвтрүүлснээр оюутнуудын эрүүл мэндийн мэдлэг, зан үйлд эерэгээр нөлөөлөх үнэ цэнэтэй боломжийг олгож байна.

Түүнчлэн шинэлэг санаачлагууд гарсаар байгаа бөгөөд эрүүл мэндийн нэр томъёог боловсролын салбарт нэгтгэх, цахим орчинд нөлөөллийн ажил явуулах, эрүүл мэндийн кампанит ажлын өдрүүдийг (Гар угаах өдөр, ХДХВ/ДОХ-ын эсрэг өдөр гэх мэт) явуулах зэрэг орно.

IV. СУРГУУЛИУДАД ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ТУЛГАРЧ БУЙ ҮНДСЭН АСУУДЛУУД

Үнэлгээний явцад тулгамдаж буй гол асуудлуудыг тодорхойлсон бөгөөд сургуулиуд зөвхөн хичээл заадаг боловсролын байгууллага тул СЭМҮ-г хэрэгжүүлэхэд ихээхэн саад бэрхшээл учирч байна. Дараах бэрхшээлүүд тулгамдаж байна. Үүнд:

Бодлого, төлөвлөгөөний тодорхой бус байдал: Яамдын бодлого, төлөвлөгөөнд тус тусдаа үйл ажиллагаанууд байгаа нь бодит үр дүн өгөх, шаардлагатай, хэрэгтэй эсэх нь тодорхойгүй байна. БШУЯ, ЭМЯ хамтраад нэгдсэн бодлогоор сургуулийн эмчийн орон тоо, түүнийг бэлтгэх, үе шаттай тогтмол сургах зэргээр 3-5 жилийн төлөвлөгөөг гаргах хэрэгтэйг мэргэжилтнүүд дурдаж байв.

Хамтын ажиллагаа, хариуцлагын тодорхой байдлыг хангах хэрэгцээ: Сургуулийн эрүүл мэндийн асуудлаар мэдээллийг авах, нэгтгэхэд нээлттэй байдаггүй тул хамтын ажиллагааг өргөжүүлэх саналыг илэрхийлж байв. Мөн хариуцлагын механизмыг тодорхой болгох, хяналт үнэлгээний үр дүнг дэмжих шаардлага тулгардаг байна.

“Мэдээлэл солилцоход хүндрэлтэй байдаг, ялангуяа сургуульд байгаа эрүүл мэндийн мэдээллийг авах, тандалтын тогтолцоотой болох хэрэгтэй байдаг. Өсвөр үеийн мэдээллийг л Боловсролын яамнаас авдаг. Өсвөр үеийнхэний дунд үе тэнгийн зөвлөх бэлтгэхийг ажил авсан цагаас хойш хийж байна. Хэрэгжилт, орчин нөхцөл байхгүй. НҮБХАС-с бэлтгэсэн хэдий ч хэрэгжилт тодорхойгүй байна. Өсвөр үеийнхний зөвөлгөө мэдээллийг үнэн зөв өгч, нөлөөлдөг хүмүүсийг бэлдэх шаардлагатай.” **(ЭМЯ-ны Нийтийн Эрүүл мэндийн газрын**

УСХЗХ-н Нөхөн үржихүй, залуучууд, эрэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Дэлхий дахины жишгээр 2011 оноос эхлэн Сургуулийн орчны эрсдэлд суурилсан хяналтыг Мэргэжлийн хяналтан ерөнхий газар, 2023 оноос ЭМЯ-ны Салбарын хяналтын газар нэршилээр жил бүр их, дунд эрсдэл бүхий объектуудад үнэлгээ хийж байна. 2024 онд 144 ЕБС, Боловсрол, Шинжлэх ухааны яамтай хамтран сургууль, цэцэрлэгийн түрээсийн байруудыг хянан шалгасан ба улмаар 36 ЕБС шаардлага хангаагүй байна.

“БШУЯ-д жил бүр хяналтын тайлангийн талаар явуулдаг хэдий ч авсан арга хэмжээний талаар эргэн хэлдэггүй, орон нутгийн засаг дарга нарт мөн илгээдэг ч энэ талаар ямар нэг арга хэмжээ авч эргэн мэдээлдэггүй. Бидний зүгээс ААН-г шаардлага хүргүүлээд хариуцлага тооцох, зөрчлийн хуулиар шийдвэрлэх боломж байдаг ч төрийн байгууллагууд, ялангуяа төрийн захиргааны удирдах байгууллагад тайлан, албан шаардлага илгээхээс өөр шийтгэх тогтолцоо, механизм бүрдээгүй байна. Сургуулийн захиралд арга хэмжээ авах талаар саналыг хүргүүлэх л боломжтой байдаг.” **(ЭМЯ-ны салбарын хяналтын мэргэжилтэн, эмэгтэй)**

Үүнд дэд бүтэц, хичээлийн хуваарь, хүний нөөцтэй холбоотой асуудлууд багтана. Гол хязгаарлалтууд нь өрөө тасалгаа, анги танхимын хүрэлцээ муу, олон тооны сурагчид, анги танхимуудыг биечлэн тусгаарласан зэрэг нь сургуулийн эмчийн үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд саад болж байна.

Хүний нөөцийн асуудлууд: 2018 онд сургуульд ажиллах нормын дагуу 481-с цөөн тооны сурагчтай сургуульд эмч ажиллахгүй гэсэн тушаалын дагуу ажлаас халах асуудлууд гарч, зарим сургуулиуд эмчгүй болсон нь хамгийн тулгамдсан асуудал байна.

Зөвхөн сургуульд суурилсан эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэхэд сургуулийн орчин төдийгүй арга, аргазүйгээр хангах, төлөвлөлт хийх түвшинд ч хүний нөөцийн дутагдалтэй, хэрэгцээ байна.

“2 салбарыг холбосон хүн байгаагүй тул ЭМЯ-ныхан нааштай хүлээн авч хамтардаг, 2 салбарын заагт байна гэдэг их чухал санагддаг тул ажилдаа дуртай байдаг хэдий ч миний тухайд ганцаардаад байгаа. Бусад чиглэлээр сургуулийн өмнөх ч гэдэг юм уу хөндлөн баг бүх газар хэд хэдэн мэргэжилтнүүдтэй, ажлаа ярилцаад хуваагаад байдаг. Миний эрүүл мэндийн асуудлаас айгаад байдаг. Ерөнхийдөө өөр салбар доторх 1 том салбарын ажил.СӨБ, ЕБС, Мэргэжлийн болон дээд боловсролын



сургалтын байгууллагын ариун цэвэр, орчин, сэтгэлзүй, цахим орчин, жирэмслэлт, өсвөр нас,охидын асуудал, эмч нарын сургалт, хөгжил, шагнал зэрэг бүх асуудлуудыг хариуцдаг. Мөн бүх өвчлөлтэй холбоотой хийсэн ажлыг эрхтэн бүрээр гаргах шаардлага гардаг. Хамтран ажиллах хүний орон тоо шаардлагатай.” (БЕГ-ийн Суралцагчийн эрүүл мэндийн асуудал хариуцсан арга зүйч мэргэжилтэн)

“Сургуулийн эмч нар хоёр салбарын дунд үлдэж, нийгмийн баталгаа нь хангагдаагүй байсаар байна. Хамгийн тулгамдсан асуудал бол сургуулийн эмч нарыг сургах, хөгжүүлэх, дэмжих орчин юм. Эмч нарын удирдлага, үйл ажиллагааг дэмжих төсөв байхгүй, сургуулийн эрүүл мэндийн төсөв байхгүй байна. (БЕГ-ийн Суралцагчийн эрүүл мэндийн асуудал хариуцсан арга зүйч мэргэжилтэн)

Сургуульд буюу Боловсролын салбарын сургалтын байгууллагад эмчээр ажилладаг тул мэргэжил аргазүйн дэмжлэгийг байгууллагаасаа авах, эмчлэх эрхийн гэрчилгээгээ сунгах, орлон ажиллах хүнгүй байх зэрэг асуудлууд үүсдэг байна. Эрүүл мэндийн салбар, байгууллагад ажиллагсадын хөдөлмөр, нийгэм хамгааллын асуудал болон сургалт, хөгжилд салбарын зүгээс анхаардаг хэдий ч бусад салбаруудад ажилладаг эмч, эмнэлгийн мэргэжилтний асуудлууд орхигдох тал байна.

“Манай салбар эмч нарын сургалтыг өөрсдөө бие даан хийх боломж бага, сургуулийн эмч нарыг сургаж эмчлэх эрх сунгах боломжтой Сургалтын модуль гарган эмч нарыг сургах хэрэгтэй. Төрөлжсөн байдлаар өөрт нь хэрэгтэй байвал эмч нар хаа, хамаагүй сургалтад сууж кредитээ сунгах асуудал тулгарахгүй.” (БЕГ-ийн Суралцагчийн эрүүл мэндийн асуудал хариуцсан арга зүйч мэргэжилтэн)

Сургуулийн эмч нарыг үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах тоног төхөөрөмжөөр хангах, ажлын байран дээрх сургалтанд хамруулах түүнчлэн ээлж солигддоггүй зэрэг орчин нь хүнд. Мөн сургуулийн эмч нарт олгогддог цалин урамшуулал жигд бус, ажлын орчинд дэмжлэг үзүүлдэггүй, шаардлагатай эд зүйл, тоног төхөөрөмжөөр хангадаггүй, мэргэжил дээшлүүлэх явцад дэмжлэг бололцоо үзүүлдэггүй зэрэг тулгамдаж буй асуудлуудаа онцолж байлаа.

“Жил бүр эмч нарын хувьд кредит цуглуулах шаардлагатай байдаг тул энэ тал дээр дэмжлэг хэрэгтэй байна. Сургуулийн орчин нь яг эмнэлгийн орчин биш учраас мэргэжлээрээ өсөн дэвших ажлын байрны



таатай нөхцлийг нөхцлийг бүрдүүлж өгөх сайжруулах шаардлагатай байна байна” **(УБ хотын гэр хорооллын сургуулийн эмч, 31 настай, эмэгтэй).**

“Улсын, хувийн сургуульд ажиллах тэнгэр, газар шиг ялгаатай. Өмнө нь улсын сургуульд ажиллахдаа 3300 хүүхэдтэй ганцаараа байхад 40% нэмэгдэл авдаггүй байсан. Одоо 645 хүүхэдтэй. Цалин өмнө нь 800.000 авдаг байсан бол одоо 1.500.000 авч байна. Улсын сургуульд ажлын үнэлгээ байхгүй, цай ч ууж амждаггүй байсан. Тэгэхэд одоо хувийн сургуульд хүүхдээ үнэгүй сургаж байна, тухтай орчинд ажиллаж байна...” **(УБ хотын хувийн сургуулийн эмч, 53 настай, эмэгтэй)**

СЭМҮ-н дэмжлэг, санхүүжилт дутмаг: Ажлын ачаалал их, цалин, нэмэлт урамшуулал, байгууллагаас дэмжлэг бага, орчин нөхцөл тааруу, ажлын байран дээрээ сурч хөгжих, өсөх боломж хомс, эцэг эхчүүдийн хүүхдэдээ тавих анхаарал, дэмжлэг сул зэрэг нийтлэг асуудлыг, харин сургуулийн эргэн тойрны орчин, аюулгүй байдал хангалтгүй, ариун цэврийн өрөөгүй зэрэг зарим асуудал сумын төвийн болон гэр хорооллын сургуулиудад түлхүү тулгамддаг байна.

“Хүүхдийн тооноос хамаарч эмч нарыг цомхотгож байна, хүүхдийн тооноос хамаарахгүй хүүхэд өвддөг шүү дээ. Саяхан Хөх-Морьт эмчийг чөлөөлсөн. Гуулин тосгон 3 сараас эмчгүй болно гэсэн.Манай аймагт 5 суманд хэзээ ажилгүй болох бол гэсэн айдастай хүмүүс л байна. Одоо яаанаа л гэсэн дарамт байна” **(Сумын сургуулийн эмч, 38 настай, эмэгтэй)**

“2021 онд төгсөөд сургуульд эмчээр анх ямар ч ойлголтгүй орж байсан. Ажлын байрны тодорхойлолтоос юу хийхээ ойлгосон. Асууж суралцах хүнгүй эхэндээ хэцүү, зарим ахмад эмч нараас асуухаар цаараглах, утсаа авахгүй үе гардаг байсан. Эрүүл мэндийн байгууллага биш учраас мэргэжлээрээ хөгжихгүй, үе тэнгийн эмч нараасаа хоцрох мэдрэмж авдаг. Миний лиценз дууссан, сургалтад хамрагдаж чадаагүй тул шалгалт өгөөд бага оноо авч их сэтгэлээр унасан...” **(Аймгийн сургуулийн эмч, 27 настай, эмэгтэй)**

Миний тухайд цэвэрлэгээ, үйлчилгээ, дотуур байр гээд илүү цаггүй ажилладаг. Хамт ажиллах хүн хэрэгтэй байдаг. Хүчилтөрөгч, сахар хэмжигч аппарат хэрэгтэй байдаг. Эцэг, эхийн оролцоо хариуцлага эрүүл мэндэд сул, тоодоггүй. Хичээл чухал гэсэн ойлголттой. Ангийн багшийн цаг ч юм уу байлгах хэрэгтэй. 1 цаг боловч төвлөрөл, бясалгал хийдэг байдлаар энэ их цахим хэрэглээг хязгаарлах, шөнөжин тоглоод хичээл дээрээ унтах, мэдрэлийн ядаргаанд орсон хүүхдүүд байна.



(Аймгийн сургуулийн эмч, 52 настай, эмэгтэй)

Ажлын нөхцөл тааруу байдал: Ер нь сургуулийн өмчийн хэлбэр, сургуулийн удирдлагуудын дэмжлэг, ойлголт чухал. Улсын сургуулиуд, ялангуяа хөдөө орон нутаг, гэр хорооллын сургуулиудад хөдөлмөрийн стандартын шаардлага хангаагүй нөхцөл, нөөц хязгаарлагдмал байдаг.

“Пульсоксометр (Зүрхний цохилт, цусан дах хүчинтөрөгчийн аппарат) байхгүй, цалингаасаа авч байсан, хэрэгтэй зүйлс зөндөө байдаг. Уг нь залуу эмч нарыг сайн сургаж, дэмжээд өгвөл заавал сургуульд ажиллахгүй гэсэн зүйл байхгүй...” **(Аймгийн сургуулийн эмч, 27 настай, эмэгтэй)**

“Зун амралтын мөнгө өгдөггүй сургуулиуд байна. Өрхийн эмнэлэгт дадлага хийлгэх байдлаар залуу эмч нарт цалинг зуны цагт өгөх хэрэгтэй, гэхдээ залуу эмч нарыг зарж болохгүй. Мөн орон нутгийн нэмэгдэл, амралтын хоног 15 өдрөөр тооцдог. Ер нь багш нараа л гэхээс ихэнх зүйлд эмч нар орхигддог.” **(Аймгийн сургуулийн эмч, 52 настай, эмэгтэй)**

“Сургуульд эмийн төсөв байхгүй, хүүхдүүд ирэхээр хоосон сууж байлтай биш ойр зуурын эмийг өөрөө авдаг.” **(Сумын сургуулийн эмч, 38 настай, эмэгтэй)**

Дүүргийн өсвөр үеийнхний эмч хэлэхдээ; ажиллах орчин нөхцөл тааруу, үзлэг хийх орчин байхгүй, шинжилгээ өгөх, явуулах тусгай орчин шаардлагатай байгааг дурдав. Эмнэлгийн удирдлагууд өсвөр үеийнхний кабинетийн үүрэг, сургуулийн сурагчдад үзүүлэх хувь нэмрийн талаар бага ойлголттой байгааг онцолж байна.

V. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭРЭГТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нэгдмэл дэмжлэгийн бодлого / хөтөлбөрүүдийг онцлон тэмдэглэв:

Боловсролын яамны төлөвлөлтөд сургалт, хичээлээр шахахаас илүүтэй нийгмийн болон эрүүл мэндийн талаас дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгцээтэй байна. Хүүхдийн хоололт, бие бялдарыг чийрэгжүүлэх, дэмжих орчин нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Мөн эрүүл мэндийн бус салбарт буюу сургалт, боловсрол, хувийн хэвшил, хувийн цэцэрлэг, уул уурхайн компаниуд гээд бусад салбарт ажиллаж буй эмч, мэргэжилтнүүдийг ЭМЯ-ны зүгээс бодлогоор дэмжих, арга аргагүйгээр хангах нэгдсэн зохион байгуулалт хийх хэрэгцээ байгааг мэргэжилтнүүд онцолж байв.

“Сургуулийн эмчийг сургуулийн захирал томилдог учир Боловсролын тогтолцоо эмчийн үүрэг, ач холбогдлыг сайн ойлгох хэрэгтэй. Мөн



Эрүүл мэндийн яамтай хамтран бүтцээ тодорхой болгохгүй бол Эмч нар салбартаа ажиллах нь дээр тул сургуульд эмч нар ажиллахгүй, цалин бага байгаа юм. Ихэвчлэн тэтгэвэрт гарсан эсвэл бага эмч нар ажилладаг. Эрүүл мэндийн салбараасаа хол учир мэргэжил, аргазүйн дэмжлэг сул, сургалт ерөнхий байдлаар тогтмол бус хийгддэг тул нарийн мэргэжил эзэмших боломжгүй, энэ талаар тусгайлсан бодлого байхгүй байна. Эрүүл мэндийн салбартай ижил цалин, нөхцөлөөр сургуулийн эмчийг хангах хэрэгтэй. Иймд хүний нөөцийн бодлогоо 2 салбар нэгтгэх хэрэгтэй байна. Сургуулийн эмчийг Их эмч байх, эсвэл нарийн мэргэшсэн байх гэсэн шаардлагууд тавихаар эмч олдодгүй. Уг нь Хүүхдийн эмчээр бэлтгэгдсэн эмч нарыг сургуульд ажилуулах, давтан сургах чухал байна.” **(ЭМЯ-ны салбарын хяналтын мэргэжилтэн, эмэгтэй)**

Эрүүл мэндийн үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх: Сургалтын орчинд эрүүл мэндийн үйлчилгээг илүү сайн төлөвлөх, хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд санал болгож болох эрүүл мэндийн тодорхой үйлчилгээг тодорхойлж, жагсаах хэрэгтэй. Хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийн дарамтын талаарх нотолгоонд үндэслэн ДЭМБ-ын удирдамжид заасан арга хэмжээний бодлогуудыг ашиглаж болно. Одоогийн байдлаар сургуулийн удирдлага, санхүүгийн хэлтэст зориулалтын төсөв байхгүй байгаа нь зарцуулалтын янз бүрийн практикт хүргэж байна. Тиймээс сургуулийн захирлын зүгээс үзүүлэх дэмжлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нь чухал.

Хүний нөөцийн асуудал: Хүний нөөцийг бүрэн орон тоогоор ажилуулах, тусдаа өрөөнүүдтэй байх зэргээр орчны асуудал, ажлын нөхцлийг сайжруулах, хэрэгцээт материалаар тогтмол хангах, харилцан уялдаатай ажиллах чухал гэдгийг онцолж байв. Мөн Эрүүл мэндийн хичээлийг өсвөр насныханд өгөөжтэй, сонирхолтой байдлаар оруулах, орчин үеийн хүүхдүүдийн хэрэгцээ их, мэдлэг мэдээллийг сошиал орчноос илүү авдаг болсон хэмээн судалгаанд оролцогчдын дийлэнх нь санал нийлж байв.

“Сургуульд эрүүл мэндийн үйлчилгээг илүү сайн хүргэх үйл ажиллагаа, арга хэмжээнд хамт олны уур амьсгал, дэмжих чиглэл нэн тэргүүнд хамгийн чухал. Ажиллах орчинд өрөөний ажиллах таатай орчин, тоног төхөөрөмж, зарим талаараа гарт барих сургалтын материалуудыг хэвлэх зэрэг тусламж их хэрэгтэй байна” **(34 настай эмэгтэй, сэтгэлзүйч)**

“Сайжруулах тал дээр гэвэл гэр бүлийн хүчирхийлэлд өртөөд ирдэг хүүхдүүд байдаг. Иймд амрах тайван өрөөг байлгах нь зүйтэй. Сэтгэлзүйчид зориулсан өрөө тасалгааг шаардлагатай нөхцлөөр бий



болгох, хүүхдүүд тайван амрах, хэсэг хугацаанд ч болов стрессгүй байх орчинг бий болгох шаардлагатай хэмээн үзэж байна. **(34 настай, эмэгтэй, нийгмийн ажилтан)**

“Сургуулийн эмч нарыг маш сайн сургаж, бэлтгэх хэрэгтэй санагддаг. Цахим хэрэглээний тал дээр хүүхдэд олон асуудал үүсч байна. Миний хувьд ажлын ачаалал гайгүй тул эрүүл мэндийн төсөл, хөтөлбөр бичдэг.” **(45 настай эмэгтэй, газарзүй-эрүүл мэндийн хичээлийн багш)**

“Эцэг эхээс зөвшөөрлийн хуудсын жишиг байхгүй. Өөрсдөө боловсруулан гаргадаг тул ямар нэг зөвшөөрлийн хуудас жишиг байдлаар гаргах шаардлагатай байна гэж бодож байна. Сэтгэлзүйч хүртээмжтэй байдаггүй тал ажиглагдсан. Сэтгэл засалч биш сэтгэлзүйч шаардлагатай. Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн эцэг эхчүүдэд мөн сэтгэлзүйн тусламж хэрэгтэй байдаг” **(31 настай эмэгтэй, сэтгэлзүйч)**.

“Сургуульд мэргэжлийн эмчийн дэмжлэг маш чухал байна. Мөн 12-р ангийн нөхөн үржихүйн ЭМ-ийн хичээл 4-р улиралд ордог. Шалгалтууд давхцаж хавар ороход хүндрэлтэй байдаг. Хүүхдүүдэд сонирхолгүй байдаг тул сурах бичгийн агуулгаас өөр туслах материал хэрэгтэй байна” **(32 настай, эмэгтэй, биеийн тамир-эрүүл мэндийн багш)**

Сургуулийн эмч нарыг сургах, чадавхжуулах: Сургуулийн эмч нарыг сургах, ажилд авах, урам зоригжуулах, чадавхжуулах нь хамгийн тулгамдсан асуудал юм. Сургуулийн эмч нарт анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж, сургалтад хамруулах, үндсэндээ эмч-багш гэсэн давхар үүрэг бүхий тусгайлсан чиг үүргийг бий болгох санал гарч байв.

Цаашид өсвөр үе буюу 10-19 насны хүүхдүүдэд уушиг, хоол боловсруулах, зүрх дотоод шүүрэл, нүд, чих хамар хоолой зэрэг хүүхдэд зонхилон тохиолдох өвчлөлөөр мэргэшсэн эмчийг бэлдэх хэрэгцээ байгаа талаар дурдлаа. Насанд хүрэгчдийн кабенитад үзүүлэхээр хүлээх, залхаад орхиж явах асуудал гардаг байна. Мөн сургуулийн эмч нар дараагийн шатлалд шилжүүлдэг албан ёсны бичиг, баримт байхгүй, өөрсдөө тодорхойлолт бичих эсвэл утсаар ярьж хүүхдээ илгээдэг байна. Мөн кабенитийн эмчид үзүүлсэн хүүхдүүдийн нэгдсэн бүртгэл байхгүй бөгөөд эмнэлгийн дотоод цахим систем бүртгэл үүсгээд шинжилгээг төлөвлөдөг, улмаар даатгал, статистикийн тасаг дээр бүртгэл, тайлан явагдаж байна.

“Урьдчилан сэргийлэх үзлэгээр өөрчлөлттэй хүүхдийг амбулатори руу илгээдэг байвал зүгээр, бид маш их холилдоод байна. **Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулагдаад амбулаториос тусдаа үзлэгээ хийх хэрэгтэй байгаа юм. Бүхэл бүтэн боловсролын маш олон мянган**



хүүхэд, ажилтнуудад эмч маш их хэрэгтэй. Манай эмнэлэгт сэтгэлзүйч, нийгмийн ажилтан, сувилагч байх хэрэгтэй тул өөрчлөлтийг АЗ99-д шинэчлэн оруулмаар байна. Зөвхөн хүүхэд үздэг тул өөр ажил зохицуул, амжуул гэдэг. Гэвч ганцаараа тул сургалт хийхэд ард зохицуулах хүнгүй, сүүлийн 6 жил сувилагчгүй байна.” **(Дүүргийн өсвөр үеийн кабенитын эмч)**

Цалингийн хэмжээ ба урамшуулал: Сургуулийн удирдлага, санхүүгийн газраас эрүүл мэндтэй холбогдох тусдаа төсөвгүй тул мөнгө зарцуулах, анхаарах байдал олон янз байна. Иймд сургуулийн захирлын дэмжлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чухал байна. Мөн сургуулийн бага эмч- ТҮ 4.1, их эмч ТҮ-5.1 буюу 1.273.000 цалинтай, үүнээсээ шимтгэл төлөөд 900 000 орчмыг гар дээрээ авдаг байна. Харамсалтай нь ур чадварын болон бусад нэмэгдлийг авах эсэх нь тухайн сургуулийн удирдлагаас хамааран өөр өөр байдаг бөгөөд орон нутагт ажилласны нэмэгдлийг зөвхөн багш, нийгмийн ажилтанд олгодог байна.

Сурагчдын эрүүл мэндэд үзүүлэх дэмжлэг, анхаарах асуудлууд: Өвдсөн хойно биш өвдөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сургууль, эцэг эхийн зүгээс хамтран авах хэрэгтэй талаар нийтлэг дурдагдсан бөгөөд шүдний өвчлөл их, өглөөний цай угаагүйгээс толгой өвдөх, гэдэс өлссөн зовиуртай хүүхдүүд их ирдэг байна. Мөн гэр бүлийн хүчирхийлэлд өртөх, эцэг эх огт хайхрахгүй байх, бэртэж гэмтсэн байдалтай сурагчид хичээлдээ ирэх тохиолдлууд гардаг. Иймд анги, сургууль дээр халуун бүлээн ус, цай уух боломжтой, сэтгэлзүйч, нийгмийн ажилтан, эмч сайн хамтрах, сургалт мэдээллийг эцэг, эхэд сурагчдын хамт цуг өгөх зэрэг анхаарахыг чухалчилж байв. Мөн эрүүл мэндийн хичээлийг эмч орох нь илүү үр дүнтэй, зүйтэй гэсэн саналууд гарч байсан.

“Эрүүл мэндийн тусдаа танхимтай, хүүхдүүд чөлөөтэй мэдээлэл солилцох, биесээсээ илүү суралцдаг тул дэмжих орчин хэрэгтэй санагддаг. Манай сургуульд саажилт, сонсголын бэршээлтэй 3 хүүхэд байдаг. Адилхан үзлэг, сургалтад хамруулна. Тэргэнцэртэй хүүхдүүдэд зориулсан орчин мэдээж хэрэгтэй. Бас сумын төвд шүдний эмч байдаггүй, аймаг явах хэрэг гардаг бэрхшээл бий.” **(Сумын сургуулийн эмч, 38 настай, эмэгтэй)**

“Эрүүл мэндийн хичээл орж буй багш нарыг чадавхжуулах, хичээл сайн орох, хуулан бичлэг хийлгэдэг, эрэгтэй багш орох үед охидод тохиромжгүй байх асуудлууд байна. Эмч-багш гэсэн мэргэжилтнүүд чухал байна. Багаараа эрүүл мэндийн чиглэлээр эмч, ажилтнууд хамтрах хэрэгтэй санагддаг. Дан ганц эмч бүх хүүхэд санаа тавих, эрүүл байлгахад үнэндээ хүрэлцдэггүй. Эрүүл мэндийн багш нар



өөрсдөө эрүүл мэндийн боловсролтой эсэх нь тодорхойгүй.” **(Аймгийн сургуулийн эмч, 52 настай, эмэгтэй)**

“Багш хүн, эмч хүн хичээл заах маш их ялгаатай. Эмч өвчин, эмгэг жам гээд бүх мэдээллээ мэддэг тул тайлбарлахаас эхлээд их ялгаатай. Багш заахаар дүн гэж, эмч заахаар эрүүл мэндийн хэрэгтэй хэвшил гэж хүлээж авдаг. Эмч нараар эрүүл мэндийн хичээлийг заалгадаг болох хэрэгтэй санагддаг”. **(УБ хотын хувийн сургуулийн эмч, 53 настай, эмэгтэй)**

3.3 СУРГУУЛИАР ДАМЖУУЛАН ҮЗҮҮЛЖ БУЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Ажиглалтын аргаар Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээний нөхцөл байдлыг Судалгаанд хамрагдсан нийт 6 сургуулиудад 5 бүлэг бүхий шалгах хуудсын дагуу үнэллээ. Үүнд:

- 1) ЕБС-тэй холбогдох эрх зүй, бодлогын баримт бичиг бүрдэл, өдөр тутмын ашиглалт,
- 2) удирдлага зохион байгуулалт, төлөвлөлтийн үзүүлэлт,
- 3) дэд бүтэц, нөөц, бэлэн байдал,
- 4) сургалт, сурталчилгаа,
- 5) эрүүл мэндийн үйлчилгээ, тандалт, үнэлгээ зэрэг юм.

1. Эрх зүй, бодлогын баримт бичиг бүрдэл, ашиглалт дээр

“Боловсролын тухай хууль” /шинэчлэсэн найруулга/, “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль /шинэчлэсэн найруулга / 2023” “Эрүүл мэндийн тухай хууль” зэрэг сургуулийн эмчийн үндсэн ажил, үүрэгт хамаарал бүхий баримт бичгийн бүрдүүлэлт цахим болон цаасан хэлбэрээр хэрхэн бүрдүүлсэн, өдөр тутам хэрхэн хэрэглэдэг талаар судлахад ихэнх тохиолдолд хангалтгүй байна. Боловсролын багц хуулийн шинэчилсэн найруулга, дархлаажуулалт, урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэгтэй холбогдох үндсэн хууль, бичиг баримтууд хангалтгүй байна. Зарим сургуульд боловсролын хуулийн шинэчлэл, өөрчлөлтийн талаар ойлголтгүй байгаа нь ажиглалт төдийгүй ярилцлагын явцад илэрхий байв. Ажиглалтын үеэр үзүүлсэн баримт бичгүүдэд үдийн хоолны холбогдох тушаал, заавар болон Коронавируст халдварын үед гарч байсан тушаал, зааврууд голлох байр суурийг эзэлж байв. Шийдвэр гаргагчид болон хэрэгжилтийг хариуцаж буй хүмүүсийн хоорондын харилцаа холбоо дутмаг байгаагаас шаардлагатай бичиг баримт дутмаг, ойлгомжгүй байдал үүсч болзошгүй. Түүгээр ч зогсохгүй чухал хууль тогтоомжийн хэрэгжилт



хангалтгүй, харилцан уялдаа холбоогүйгээс оюутнуудын эрүүл мэндэд ч эрсдэлтэй учирч болзошгүй юм.

Харин эмчийн ажлын байрны тодорхойлолт болон тодорхойлолтын хавсралт бүхий эмчийн өрөөнд байх шаардлагатай эм, хэрэгслийн жагсаалтыг хэвлэсэн, хавтасласан, нүдэнд харагдахуйц байршуулах зэргээр өдөр тутам даган мөрдөж, хэвшсэн байгаа нь ажиглагдлаа.



Зураг 2. Эмч нарын бичиг хэргийн шүүгээ

2.Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлтөд үнэлгээнд хамрагдсан сургуулиуд бага (4) болон их эмчтэй (2) бөгөөд үндсэн мэргэшлийн сургалтад хамрагдаж эмчлэх эрх бүхий лицензтэй байв. Эмчийн өдөр тутмын үйл ажиллагааны үндсэн бичиг баримт, төлөвлөлтийг үнэлэхэд өөр, өөрсдийн тухайн жилийн ажлын төлөвлөгөөг сургуулийн захирлаар батлуулсан байв. Эмчийн ажлын төлөвлөгөөнд урьдчилан сэргийлэх үзлэг, сургалт сурчилгаа хийх, тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэх, товлот дархлаажуулалтад хамруулах зэрэг ажлууд голчлон орсон байв. Харин халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, арга хэмжээний төлөвлөгөөг тусгайлан гаргаагүй, халдварт өвчинтэй холбоотой мэдээллийн хуудас, бүртгэл, халдварт өвчин гарсан тохиолдолд голомтын хариу арга хэмжээг цаг алдалгүй авах төлөвлөгөө, мэдээлэл дамжуулах зураглал зэрэг тодорхой бус байдал нийтлэг ажиглагдсан. Төлөвлөгөө эсвэл хяналт байхгүй байгаа нь СЭМҮ-ний талаар нэгдсэн бодлогогүй эсвэл ойлголт дутмаг байж болзошгүйг харуулж байна. Бүх сургуулиуд ариутгал, халдваргүйтгэлийг тухайн сургуультай гэрээ бүхий компаниар жилд 1-2 удаа гүйцэтгүүлдэг байна.

хариуцлага тооцох нь бараг боломжгүй юм.

Сумын төвийн сургуулийн эмчийн өрөөнд компьютер, хэвлэх машин байхгүй, үзлэгийн ор гэсэн хэдий ч зориулалтын бус хавтгай мод байршуулан бүтээлгээр бүтээсэн байв. Харин УБ хотын сургуулиудын эмчийн өрөөний орчин, нөхцөл, тохижилт харьцангуй сайн байна.



Зураг 4. Эмчийн өрөөний хэрэглэгдэхүүн


4.Эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны материал, нөөцийг үнэлэхэд сурагч, багш, ажиллагсдад чиглэсэн жилийн төлөвлөгөө үйл ажиллагааны хэрэгжүүлдэг сургуулиуд байсан. Зарим сургууль суралцагчийн нас хүйс, биеийн онцлогт тохирсон нөхөн үржихүйн эрүүл мэнд болон анхан шатны тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн сургалтыг зохион байгуулдаг давуу талтай байна. Гэхдээ тус сургалтуудын давтамж, агуулга, хүртээмжтэй байдал бүр харьцангуй байна. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хэрэгцээнд тулгуурласан ганцаарчилсан зөвлөгөө, хөтөлбөрийн дагуу сургалт хангалтгүй (УБ хотын сургуулиудад) хэрэгжүүлж байгаа нь шалгуур үзүүлэлтээс харагдсан. Сурагчдад чиглэсэн эрүүл мэндийн мэдлэг, мэдээлэл олгох сургалт, сурталчилгааны материалууд 8 үндсэн агуулгын хүрээнд 20 гаруй төрлөөр буюу нөхөн үржихүй, хорт зуршил, хоол хүнсний зохистой хэрэглээ, сэтгэлзүйн дэмжлэг, үе тэнгийн дээрэлхэлт, гарын ариун цэвэр зэрэг агуулгууд ихэнх материалыг эзэлж байв. 2015 оноос 2023 оны хооронд хэвлэгдсэн төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудаас хэвлэн гаргасан тараах материалууд түгээмэл байна.





Зураг 5. Сургалт, сурталчилгааны материал

5.Эрүүл мэндийн үйлчилгээ, тандалт, үнэлгээний хүрээнд эмчийн ажил, үүрэгт дурдагдснаар сурагчид (багш, ажиллагсад)-ыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах үйл ажиллагааг сургуулиуд жилд 1 удаа үзүүлдэг байна. Харин халдварт өвчин тархах эрсдэлтэй орчинд сургууль тооцогддог хэдий ч урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хангалтгүй үнэлгээтэй байна. Сурагчдын ирцийн бүртгэлийн хяналт, халдварт өвчний тандалтын бүртгэл, үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах албан ёсны хуудас зэрэг байхгүй байна. Үнэлгээнд хамрагдсан сургуулиудад сурагчийн эрүүл мэндийн карт хөтлөлт хийгддэггүй бөгөөд үнэлгээнд хамрагдсан зөвхөн 1 сургуульд улс даяар хийгдэж буй Эрт илрүүлгийн үйл ажиллагаатай холбогдуулан 2022 оноос хойш электрон өгөгдөл үүсгэж эхлэсэн байна. Сургуулиуд өөрсдийн нөөц бололцоо, чадавхидаа үндэслэн оюутны эрүүл мэндийн картыг цахим болон цаасан хэлбэрээр гаргаж болно. Харамсалтай нь үнэлгээнд хамрагдсан сургуулиуд эрүүл мэндийн тандалт, лавлагаа, тайлагнах хууль эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлээгүй байна.



Зураг 6. Эмчийн бүртгэл, үзлэгийн дэвтэр

Доорх хүснэгтэд хувийн болон төрийн өмчид суурилсан сургуулиудын

ерөнхий нөхцөл, нөөцийг үндсэн 5 ангиллаар харуулсан болно.

Хүснэгт 7. Сургуулиудын эрүүл мэндийн үйлчилгээний нөөц, нөхцөл байдлыг өмчлөлөөр нь харьцуулсан байдал

	Үнэлгээний ангилал	Төрийн өмчийн (5 сургууль)	Хувийн өмчийн (1 сургууль)
1.	Холбогдох эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдийг эмхэтгэн ашиглах	<ul style="list-style-type: none"> Хязгаарлагдмал бичиг баримт (Үдийн цайны хөтөлбөр, эрүүл ахуй) Системчилсэн мэдээллийн урсгал байхгүй 	<ul style="list-style-type: none"> Хязгаарлагдмал баримт бичиг Системчилсэн мэдээллийн урсгал байхгүй
2.	Менежмент ба төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> Сургуулийн эмч, сэтгэл зүйч, хоол зүйч (5/3) 	<ul style="list-style-type: none"> Сургуулийн эмч
3.	Дэд бүтэц, нөөц, хүртээмж	<ul style="list-style-type: none"> Ажлын доод нөхцөл (5/4) Хязгаарлагдмал уян хатан байдал ба нөөц (5/4) Сургуулийн тоног төхөөрөмжийн хүртээмж бага Сурагчдын тоо өндөр 	<ul style="list-style-type: none"> Ажлын тав тухтай нөхцөл Хангалттай хангамж, нөөц Сурагчдын тоо бага
4.	Сургалт, сурталчилгаа	<ul style="list-style-type: none"> 8 үндсэн агуулга бүхий нийт 20 төрөл Сэтгэцийн эрүүл мэндийн талаархи зөвлөгөө Эрүүл мэндийн боловсролын сургалтын хөтөлбөр 	<ul style="list-style-type: none"> 6 үндсэн агуулга бүхий нийт 10 төрөл Сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөө Эрүүл мэндийн боловсролын сургалтын хөтөлбөр
5.	Эрүүл мэндийн үйлчилгээ, тандалт, үнэлгээ	<ul style="list-style-type: none"> ӨЭМТ, орон нутгийн эмнэлгүүдтэй хамтран ажилдаг Хяналт байхгүй 	<ul style="list-style-type: none"> Эцэг эхтэй хамтран ажилдаг Хяналт байхгүй Ердийн үзлэг



ҮР ДҮН-4 СУРГУУЛИАР ДАМЖУУЛАН ҮЗҮҮЛЖ БУЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮЛЭЭН АВАГЧДЫН ОЙЛГОЛТ, ХҮЛЭЭЛТ

I. Сурагчдийн эцэг, эх/ асран хамгаалагчдын үйлчилгээний талаарх ойлголт, сэтгэгдэл

“Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээ” гэдгийг хэрхэн ойлгодог, ямар үйлчилгээ авч байсан талаар тодруулахад ярилцлагад оролцсон эхчүүд энэ талаар ойлголт бага, сайн мэдэхгүй гэдгээ илэрхийлж байв. Зарим тохиолдолд үзлэг оношилгоог сайн хийж онош тавих, чөлөөний хуудас өгөх, сургалт мэдээллийг хангалттай хийдэггүй тул сэтгэл дундуур байгаагаа илэрхийлж байв.

“Сургуулийн орчинд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг гэж хэлэхэд хүндрэлтэй. Яагаад гэвэл эрүүл мэндтэй холбоотой арга хэмжээ, үйл ажиллагаа хангалттай хэмжээнд зохион байгуулагддаггүй, эрүүл мэндийн чиглэлийн мэдээлэл хомс байдаг. Хааяа биед ямар нэг зовиур илэрсэн тохиолдолд тухайн үедээ сургуулийн эмчид үзүүлж зөвлөгөө авдаг юм шиг байгаа юм. Нарийн чиглэлээр өрхийн эмчид үзүүлж акт авдаг” **(6 болон 9-р ангийн сурагчдын ээж, 49 настай)**

“Хүүхэд сургууль дээрээ байх үедээ хэрэгцээтэй эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ авахыг хэлнэ. Мөн хүүхдийг багаас нь эхлэн халдварт өвчний чиглэлээр судалгаа авч, охидын гэлтгүй эрэгтэй хүүхдүүдэд ч нөхөн үржихүйн, бие бялдар, өвчин тусахаас сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааг хэлэх байх” **(4-р ангийн сурагчийн ээж, 27 настай)**

“Сургуульд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэх зүйл байдаггүй мэт санагддаг. Яагаад гэвэл хүүхдүүд эмчийн өрөөнд очиход эмч байхгүй эсвэл үзээд онош тавьдаггүй, акт өгөхгүй, эмнэлэг явж үзүүл гэдэг. Сургуулийн эмчтэй бол би уулзаж байгаагүй. Хүүхэд акт авах гэхэд байхгүй. Иймд сургуульд эмчийн хэрэгцээ байна уу гэж бодож байна. Гэнэт өвдөх, ханиад хүрэх гэх мэт анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлдэг л байх” **(7-р ангийн сурагчийн ээж, 41 настай)**

II. Сургуулийн орчинд эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой сайжруулах шаардлагатай нөхцөл, тулгамдсан асуудал

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх: Нэн тэргүүний тулгамдсан асуудалд нөхөн үржихүйн боловсролыг цэгцтэй олгох, дунд, ахлах ангийн сурагчдын сургуулийн орчинд идэж буй хүнс,

хоол болон сургуулийн орчинд сурагчид амрах, дасгал хийх зэргээр чөлөөтэй ашиглах боломжтой өрөө тасалгаа, кабенит тохижуулах талаар нийтлэг талаар дурдаж байв. Эцэг, эхчүүдэд сургууль дээр болж буй арга хэмжээ, эрүүл мэндийн үйлчилгээний талаар төдийлэн мэдээлэл хүрдэггүй байна.

Сургуулийн орчин дахь хоол тэжээлийг сайжруулах: Эцэг эхчүүд сургуулийн орчинд дунд болон ахлах ангийн сурагчдад зориулсан хоолны сонголтуудын талаар санаа зовж байна.

Сургуулийн орчинд дунд, ахлах ангийн сурагчдад зориулсан хоолны сонголт ч эцэг эхчүүдэд санаа зовдог. Оюутнуудын хоолны дэглэмийн хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсэн эрүүл, тэжээллэг хоолны сонголтоор хангахын чухлыг онцолж байна.

“...Сургуулийн орчинд гаднаас хүмүүс хоол авч ирж зардаг. Үүнд сургуулийн зүгээс шаардлага тавьж, хяналт байнга тавих шаардлагатай байх. Мөн нөхөн үржихүйн мэдээллээр сайтар хангах, хүсээгүй жирэмслэлт, гэр бүл төлөвлөлт зэрэг зөвлөмж өгөх хэрэгтэй гэж бодож байна.

(41 настай 7-р ангийн хүүхдийн ээж)

Биеийн тамирын талбайг сайжруулах: Сургуулийн дотор оюутнууд амарч, биеийн тамирын дасгал хийх боломжтой илүү олон өрөө, орон зай шаардлагатай гэдэгт ерөнхий санал нэг байна. Энэ нь хичээлийн цагаар сурагчдын бие бялдар, оюун санааны хөгжихөд туслахад шаардлагатай эрэлт хэрэгцээ байгааг харуулж байна.

“Сургуулийн зүгээс эрүүл мэндийн чиглэлээр ямар арга хэмжээ, юу зохион байгуулдагыг сайн мэдэхгүй. Сургуулийн эмч эрүүл мэндийн боловсролын чиглэлээр хэрэгтэй зөвлөмж, зөвлөгөө мэдээлэл өгөх хэрэгтэй. Хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх дасгал, амралтын өрөөг сургууль дээр тохижуулах хэрэгтэй гэж бодож байна. Сард 1 удаа витаминжуулалтын аян хийх саналтай, сургуулийн зүгээс эмчийн санаачилсан арга хэмжээг дэмжээсэй гэж хүсэж байна. Эрүүл мэндийн хичээлийг бага ангид орох нь зөв үү эсвэл дунд ангиас эхэлж орох нь зөв үү гэдэг дээр эцэг эх бидэнд мэдээлэл өгөх нь зөв байх...”

(27 настай, 4-р ангийн хүүхдийн ээж)

Сургуулийн орчин дахь сурагчдын аюулгүй байдал, мэдээлэл нээлтэй байх, хөгжих орон зайг бий болгох, анги болон нийтээр гэхгүйгээр



зөвөлгөө, мэдээлэл, эрүүл мэндийн үйлчилгээг ганцаарчлан авах боломжтой, нөхцөлөөр хангах чухал байна.

“...Захын сургуулийн тухайд хүүхдүүдийг сургууль дээр ирэх, явахад анхаарах нь аюул, осол гэмтэл, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжит нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй. Манай хүүхэд саажилттай хэдий ч тэргэнцэрт дургүй учраас хүргэж өгөх, авахдаа зөөдөг. Одоохондоо орж гарахад нь гараараа өргөж дийлдэг, хичээлийн үеэр ангийнхан нь тусалдаг. Ганцаараа ирж очдог хүүхдүүдэд зам, халтиргаа, шавхай ихтэй хэцүү байдаг” (27 настай, 4-р ангийн хүүхдийн ээж)

Эрүүл мэндийн үйлчилгээний мэдээллийн харилцааны цоорхой:

Эцэг эхчүүдийн онцолж буй гол асуудал бол сургууль дээр байгаа эрүүл мэндийн арга хэмжээ, үйлчилгээний талаарх мэдээлэл дутмаг байдаг. Сургуулийн зарим сурагчийн эрүүл мэндийн асуудал гарч байгааг хүүхдүүдээс нь сонсдог гэдгийг эцэг эхчүүд онцолж байлаа. Сургуулиас ийм албан ёсны мэдээллийн урсгал, хүргэлт байхгүй. Хааяа нэг сургуулиас эцэг эхийн зөвшөөрлийн вакцины хуудас авдаг. Сургуулийн ажилтнууд, сургуулийн эмч нар эцэг эхчүүдийн идэвхгүй оролцоог онцолсон ч эцэг эхчүүдэд сургуулийн үйл ажиллагаанд тогтмол мэдээлэл өгөх мэдээллийн урсгал дутмаг байна. Тиймээс оюутнуудын эрүүл мэндийг сайжруулах нэгдмэл зорилгын төлөө харилцан ойлголцол, хамтын ажиллагаа байхгүй байна.

Сургуулийн эмч нарын үүргийн талаархи нийтлэг ойлголтыг бий

болгох: Эцэг эхчүүдийн хүлээлт нь оюутнуудад яаралтай тусламж, эрүүл мэндийн нөхцөл шаардлагатай үед сургуулийн эмч нарын үүргийг тодорхой болгох явдал юм.

“Эмчийн үүргийг нэмэх, сургуулийн эмчээс айх зүйлгүй шууд харилцах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй байна. Эрүүл мэндийн боловсрол олгох, биеийн тамир, спорт бие бялдрыг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй. Эрүүл мэндийн хичээл дээр өсвөр үе, бие бялдар, биеийн ариун цэврийн талаар илүү орвол сайн. Долоо хоног тутам сургуулийн эмч эрүүл зөв хоололт, эрүүл чийрэг бие бялдар болон амьдралын зөв дадал чиглэлээр тогтмол мэдээлэл зөвлөгөө өгдөг байх хэрэгтэй...” (41 настай 7-р ангийн хүүхдийн ээж)

“...Гол нь сургууль дээр эмч байнга байж, эмнэлгийн анхан



шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлдэг байх нь чухал гол хэрэгцээ юм болов уу гэж бодож байна. Эмч болон сэтгэлзүйчтэй ганцаарчилсан байдлаар уулзалт хийж наад захын мэдээлэл болох сурагчдын ариун цэвэр, сарын тэмдэг, нөхөн үржихүйн талаар мэдээлэл өгвөл илүү ойлгомжтой байх болов уу гэж бодож байна. Бүх сурагчдын дунд ярилцлага, сургалт гэх мэт хийхээр хүүхдүүд тоодоггүй. Мөн охидод нэн тэргүүнд шаардлага тулгардаг асуудал бол ариун цэврийн хэрэглэл юм. Ариун цэврийн булан байдаг гэсэн гэхдээ байгууллагын түвшинд бүхнийг хангах хэрэгцээ байдаггүй учир охид өөрсдөө дамск нөхөж хийдэг. Эмчийг удирдлагын зүгээс сайн дэмжлэг үзүүлэх боломжтой гэж харж байна.” (49 настай, 6 болон 9-р ангийн хүүхдүүдийн ээж)

III. Сурагчдын зүгээс эрүүл мэндтэй холбогдох арга хэмжээ, үйлчилгээний талаарх сэтгэгдэл, туршлага

Сурагчдын ойлголтууд: Сургуулийн орчинд хүлээн авч байсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон сэтгэгдлийг бүлгийн ярилцлагаар тодруулахад сурагчид өөрсдөө болон ангийн хүүхдүүд нь сургуулийн эмчид үзүүлж эм авч, хичээлээс түр чөлөөлөгдөж байсан талаар дурдав. Харин өдөр тутмын эмчийн ажил үүргийн талаар тодруулахад бэртэл гэмтэл авсан, бие өвдсөн үед тусламж үзүүлэх, эмчийн үзлэг хийх, өрхийн эмчтэй хамтрах, сургалт хийх, ангийн ариун цэвэр шалгах ажлууд хийх хэмээн хариулсан байна. Мөн сэтгэлзүйчтэй ангиараа яриа өрнүүлж байсан зэргийг дурдав.

“...Би ханиадтай байсан, эмчид үзүүлээд эмчилгээ бичиж авсан. Эмчид эм байвал өгдөг, заримдаа ходоодоо үзүүлнэ, тухайн үед эм ууж байсан .” **9-р ангийн сурагч, эмэгтэй**

“Огт үзүүлж байгаагүй. Халуурсан, бөөлжсөн үед ирж эм уудаг юм шиг байна лээ...” **11 дугаар ангийн сурагч, эрэгтэй**

“Эмч урьдчилсан үзлэг сайн хийдэг, тэрүүгээр биеийн байдал нь гараад ирдэг...” **9-р ангийн сурагч, эмэгтэй**

“Эмчийн өрөө доод сургуульд байдаг, эмч дуудахаар ирдэг. Үзлэг хийхэд хэрэгтэй зүйлс байхгүй юм шиг санагдсан...” **12 дугаар ангийн сурагч, эрэгтэй**



Эрүүл мэндийн хөтөлбөрт оюутнуудын оролцоо: Сурагчид сургуулийнхаа эрүүл мэндийн багт оролцон эрүүл мэндийн хөтөлбөр, үйлчилгээнд оролцож, дэмжлэг үзүүлэх нь түгээмэл байна. Энэ нь сургуулийн эмч нарт ихээхэн туслалцаа үзүүлдэг бөгөөд эрүүл мэндийн баг ихэвчлэн үе тэнгийнхэндээ сургалт явуулдаг.

“...Би эрүүл мэндийн сургалтыг эмчтэй хамтраад зохион байгуулдаг, эртнээс төлөвлөөд хийдэг болохоор зохион байгуулалт сайтай болдог. Янз бүрийн сэдвүүдээр ордог, сүүлд яаралтай тусламжийн талаар мэдлэг олгох сургалт орсон.” **9-р ангийн сурагч, эмэгтэй**

IV. Сурагчдад тулгамддаг асуудал, бэрхшээл

Үйлчилгээний бэлэн байдал: Фокус бүлгийн ярилцлагын үеэр зарим сурагчид эмч шаардлагатай үед тэднийг олдоггүй тиймээс тэднийг ажлын байрандаа эсвэл өрөөнд байх нь чухал гэдгийг онцлон тэмдэглэв. Мөн анги танхимын цэвэр цэмцгэр байдлыг хангах, цэвэрлэгч нарт заавар зөвлөгөө өгөх нь эмчийн үүрэг гэдгийг тэд дурдав. Эмч үзлэг шинжилгээнд хамрагдахаар эзгүй үед түүнийг орлох эмч эсвэл туслах хүн байх шаардлагатай. Түүгээр ч зогсохгүй эмч нарт өдөр бүр хангалттай эм, үзлэгийн багаж хэрэгсэл дутагдаж байгааг сурагчид аль хэдийн ажиглажээ.

“Манай ангийн 2 охин үзүүлсэн чинь ус уугаад зүгээр болохгүй бол акт бичие гэсэн гэсэн, яаж ч өвдөөд ирсэн өвчин намдаагч л өгдөг, эм авах мөнгөгүй байдаг юм болов уу? Тэрийг бол сайн мэдэхгүй байна...” **9-р ангийн сурагч, эрэгтэй**

Эрүүл мэндийн мэргэжилтнүүд хүртээмжтэй байх: Сэтгэл зүйч, эмч, хоол тэжээлийн мэргэжилтнүүд зэрэг эрүүл мэндийн мэргэжилтнүүд шаардлагатай байгаа талаар санал нэг байна. Мөн сурагчдын өдөр тутам тулгардаг олон асуултыг (батга, сарын тэмдэг, секс гэх мэт) тайлбарлах, зөвөлгөө өгөх, сурагчдад ээлтэй орчин бүрдүүлэх хэрэгтэй байна.

“Бидний биед шилжилтийн насны өөрчлөлтүүд их байдаг тул хувьчлан зөвөлгөө өгдөг эмч байвал гоё. Анги бүрт эмийн сан байвал зүгээр санагдсан. Эмч өглөөний цаг дээр ирээгүй байдаг болохоор өвдсөн үед 9 цаг өнгөртөл хүлээх хэрэг гардаг, заримдаа эмчийн өрөөнд очихоор байдаггүй.” **9-р ангийн сурагч, эмэгтэй**

Дэд бүтэц, хүртээмж: Сургуулийн гадаа бие засах газар орох, анги нь хүйтэн, тав тухгүй, гараа угаах угаалтуургүй гэх мэт орчин нөхцөл



байдлаас шалтгаалж их хүндрэлтэй байдаг. Зарим сургуульд эмчийн өрөө нь өөр сургуулийн байранд байрладаг бөгөөд зарим тохиолдолд эмчийг хүлээж байгаа нь тэднийг дур мэдэн эм уух, өөр эмнэлэгт хандах гэх мэт өөр сонголтуудыг эрэлхийлэхэд хүргэдэг.

“Өвөл гадаа гарч бие засахад л хамгийн хэцүү. Айдастай, халтиргаатай бас эрэгтэй, эмэгтэй нэг, нэг ширхэг л жорлонтой болохоор хүлээж оочирлодог. Энэ хичээлийн байранд гараа угаах угаагуур байдаг гэхдээ нэг нь ч ажилладаггүй. Уг нь доод сургуульд гоожуурт ус хийгээд угаадаг байсан...” **11-р ангийн сурагч, эмэгтэй**

Эрүүл мэндийн цогц боловсрол олгох хэрэгцээ: Дунд, ахлах ангийн сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зөвхөн онолын мэдлэгээр бус амьдралд хэрэгжүүлэх, дадал хэвшил бий болгох талаас нь идэвхтэй, сонирхолтойгоор заах нь илүү үр өгөөжтэй байдаг байна.

Сэтгэцийн эрүүл мэнд: Эмнэлэг дэх өсвөр үеийн эмч нарын дэмжлэгээс гадна сурагчид, эцэг эхчүүдэд сэтгэцийн эрүүл мэнд, цахим хэрэглээ, донтолтын талаарх мэдлэгийг дээшлүүлэх сургалт, арга хэмжээ, мэдээллийн агуулга нийтлэг хэрэгцээ байна. Түрэмгий, ууртай, ичимхий сурагчдад тусламж хэрэгтэй байдаг ч анги, бүлгээр хичээл, сургалт явуулах нь тийм ч үр дүнтэй, үр өгөөжтэй биш гэдгийг онцолж байлаа.

“Миний тухайд сэтгэлзүйн зөвөлгөө чухал санагддаг. Эцэг, эхтэй хамт уулзалт зохион байгуулбал сайн. Хүүхдээ ойлгодоггүй, хайхардаггүй хүмүүс их байдаг.” **9-р ангийн сурагч, эмэгтэй**

Хоол тэжээлийн асуудал, хоолны үйлчилгээ: Сурагчид үдийн цайны хөтөлбөрт хамрагдах, ялангуяа 6-9-р ангийн сурагчид хамрагдах шаардлагатайг илэрхийлэв. Завсарлагааны үеэр идэх зүйл олоход хэцүү байдаг. Хоол хүнс нь үнэтэй, эрүүл бус (түргэн) хоол, хоолны сонголтгүйгээс гадна урт дараалал үүсдэг.

“Сургууль дээр юм худалдаж авахаа болисон, ус, ундаагаар болгох эсвэл хааяа печенье иддэг, өнгөрсөн жил манай сургуулийн бүх хүүхдүүдээс дунд, ахлах ангийнханд үдийн цай өгөх хэрэгсэл, төхөөрөмж авна гээд 25.000 төгрөг хураасан. Одоо болтол байхгүй, завсарлагаанаар өлсөөд л байдаг.” **9-р ангийн сурагч, эрэгтэй**

“Сургууль дээр идэх зүйлс пирошки гэгчхээд хатсан гурил өгдөг, заримдаа гараараа барьснаа өгдөг. Хоолны амт, чанар сул.



Уг нь өнгөрсөн жил 1000 гэдэг байсан, энэ жил 1500 болцон байна лээ, одоо 1800 болсон хэзээ 2000 болохыг мэдэхгүй. Үнэ нэмэгдээд байгаа хэрнээ амтгүй. Мантуун бууз нь хальс шиг жаахан махтай, таван цул шиг амтагддаг..” **9-р ангийн сурагч, эрэгтэй**

Хүйсийн онцлогт тохирсон байгууламж, хэрэгцээ: Охид биеийн тамирын хичээлд явахдаа хувцас солих өрөөгүй байдаг, завсарлагаанаар 5-10 минут бие засах, жорлон хүлээх, хүлээх зэрэг асуудлуудыг илэн далангүй дурдав. Тиймээс сургуулийн орчинд ч гэсэн жендэрт суурилсан төлөвлөлтийг сурагчдад ээлтэй уур амьсгалыг бий болгохын тулд анхаарч үзэх хэрэгтэй.

Ариун цэврийн булан 2 жилийн өмнөөс байдаг болсон. Ариун цэврийн хэрэглэл авч болдог. Нойлын өрөө болон нийгмийн ажилтны өрөөнд байдаг. Түлхүүрийг нь нийгмийн ажилтнаас аваад хэрэглэж болдог. Яаралтай үед нийгмийн ажилтанг хайхгүйгээр цэвэрлэгч нараас авч болдог ч юм уу тийм байвал хэрэгтэй санагдсан. Хэрэглэсэн бол дараа нь нөхөөд хийдэг юм чинь уг нь. Бас хорт зуршлын талаар сайн мэдээлэл өгвөл хэрэгтэй санагдсан. **9-р ангийн сурагч, эмэгтэй**

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Зорилго 1-н хүрээнд Хууль эрхзүйн орчны хүрээнд сургуулийн эмчийг үндсэн орон тоонд багтаасан хэдий ч ажлын ачаалал, сургууль, хичээлийн байрны байршил, бусад нөхцөл байдлыг харгалзан уян хатан байдлаар норм, норматив батлагдаагүй байна. Сургуулийн эмчийн ажлын байрны тодорхойлолтод 2 үндсэн чиг үүрэг бүхий 21 заалт орсон бөгөөд эрүүл ахуйч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэний чиг үүргүүд ч багтжээ. Мөн цалингийн шатлалд Боловсролын байгууллага тул эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эмч нараас доогуур, төрийн үйлчилгээний ажилтнуудын орон нутагт ажилласны нэмэлт урамшуулалд сургуулийн эмчийг орхигдуулсан байна.

2019 оны Монгол Улсын Стандарт буюу Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал ерөнхий шаардлага MNS 6782 2019-д эмчийн өрөөг оруулж сурагчийн эрүүл мэндийн карт, карт хадаглах шүүгээ болон нийгмийн эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны багцыг нэмж дурдсанаараа 2018 оны хамтарсан сайдын тушаал бүхий жагсаалтаас дэвшилттэй байна.

Сургуулийн өмнөх болон Ерөнхий Боловсролын Тухай Хуульд сургуулийн удирдах болон бусад ажилтны үүрэгт суралцагчийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах,



хяналт тавих ажлыг албан тушаалын ялгаагүй бүх ажилтнуудын үүрэг болгон заасан, мөн нутгийн удирдлагын үүрэг, хариуцлагад ЕБС-ийн суралцагчийн эрүүл мэндийн хяналт, үзлэг, оношлогоог тусгаснаараа онцлог байна. Харамсалтай нь бодит байдал дээр нэгдсэн бүртгэл, хяналт хийгдэж эхлээгүй, хуулийн шинэчлэлийг сонсоогүй, мэдээгүй мэргэжилтнүүд цөөнгүй байна. Боловсролын Тухай Ерөнхий Хуулийн 10-р заалтад дурдсаны дагуу эцэг, эхийн зөвшөөрөлгүй сэтгэлзүйн зөвөлгөө, дэмжлэг авах боломжгүй байна. Улмаар тусламж үйлчилгээг сэтгэлзүйн чиглэлээр үзүүлэхээс татгалзах, тусламж авах боломж хязгаарлагдах, цаг алдах эрсдлүүд үүсч болзошгүй байна.

Зорилго 2-н хүрээнд Боловсрол болон эрүүл мэндийн салбарт Сургуулийн эрүүл мэндийн нэгдсэн бодлого, төлөвлөлт байхгүй байна. Мөн эмчгүй сургуулиуд байдаг байна. БСШУСС, СС-н 2018 оны А/024/11 буюу Орон тооны жишиг норматив батлах тухай тушаалын дагуу ажлаас халах асуудлууд гарч, зарим сургуулиуд эмчгүй болсон нь тулгамдсан асуудал болоод байна. Сургуулийн эмч нарын ажлын ачаалал их боловч цалин, нэмэлт урамшуулал, байгууллагын дэмжлэг бага, ажлын орчин нөхцөл тааруу, ажлын байран дээрээ хөгжих боломж хомс, сургалтад хамрагдаж эмчлэх эрхийн гэрчилгээгээ сунгах, орлон ажиллах хүнгүй байх зэрэг нийтлэг асуудлууд тулгамддаг байна. Мөн эрүүл мэндийн бус салбарт буюу сургалт, боловсрол, хувийн хэвшил, хувийн цэцэрлэг зэрэг бусад салбарт ажиллаж буй эмч, мэргэжилтнүүдийг ЭМЯ-ны зүгээс бодлогоор дэмжих, арга аргагүйгээр хангах нэгдсэн зохион байгуулалт хийх хэрэгцээ байна.

Боловсролын яамны төлөвлөлтөд сургалт, хичээлийг оруулахаас гадна нийгмийн болон эрүүл мэндийн талаас дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгцээтэй байна. Хүүхдийн хоололт, бие бялдарыг чийрэгжүүлэх, дэмжих орчин нөхцөлийг бүрдүүлэх, сурагчдын амрах, тайвшрах орчин, өрөөг гаргах зэрэг тулгамдсан асуудлуудыг цогцоор харах, шийдвэрлэх шаардлага тулгамдаж байна. Мөн сумын болон гэр хорооллын сургуулиуд, хичээлийн байрны хоорондын зай, сурагчдын тоо, сургуулийн бусад нөхцөл байдлыг харгалзан уян хатан төлөвлөлт хийх, шийдвэр гаргах нь зүйтэй байна.

Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээг багаар хамтран хийх, эцэг, эхэд мэдээлэл өгч, хамтран ажиллах, урьдчилан сэргийлэх үзлэгийн үр дүнд эргэн хяналт тавих байдлаар үр нөлөөг бий болгоход анхаарах шаардлагатай.

Зорилго 3-н хүрээнд Стандартын дагуу эмчийн өрөө, тусгаарлах өрөө, эм, хэрэгсэл бүхий сургууль ховор байна. Хууль, тогтоомж болон



холбогдох тушаал зааврын талаар мэдлэг сул, мэдээлэл багатай нийтлэг дүр зурагтай байна. Мөн сургуулийн эмчийн ажил үүрэгт халдварт өвчний тандалтыг хийх чухал байр суурь эзлэх хэдий ч бүртгэл, тандалт хийгддэггүй. Сургуулийн анги, танхимд олон тооны сурагчид удаан хугацаагаар суух нь халдварт өвчин тархах эрсдэлтэй орчин тул эмч нэн тэргүүнд эрсдлийг бууруулах, хариу арга хэмжээ авах зэргээр бэлэн байдлыг хангах, төлөвлөх, холбогдох нөөц, хангамжтай байх хэрэгцээтэй байна. Мөн халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх арга хэмжээ, мэдээллийн урсгал, тусгаарлах байр, халдварт өвчний мэдээллэх хуудас, сурагчдын эрүүл мэндийн бүртгэл хөтлөх, эцэг эх-багш нартай эргэх холбоо, тогтолцоо үүсгэх, хэрэгжүүлэх шаардлагатай байна. Зовиур бүхий сурагчдад зарим нэр төрлийн өвдөлт намдаах болон шинж тэмдгийг дарах эмийг уулгадаг бөгөөд зарим эмч нар чөлөөний хуудас бичих, эсвэл шууд өрх дүүргийн эмнэлэгт үзүүлэхийг зөвлөдөг байна. Харин эмч нарын ихэнх цаг ариун цэвэр, эрүүл ахуйг шалгах, хоолны цэс зохиох, үдийн цай хөтөлбөрт хяналт тавих үүрэгт хөтлөгдөж байгаа нь анзаарагдлаа. Сургуулийн эмчийн өдөр тутмын ажилд шаардагдах эм, багаж хэрэгслүүд харилцан адилгүй, ихэнх тохиолдолд хангалтгүй байна. Сумын төвийн сургуулийн эмч эмийн нөөц, ажлын бусад хангамжгүй шахам байна.

Зорилго 4-н хүрээнд Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээ, цар хүрээний талаар эцэг, эх, асран хамгаалагчид төдийлөн ойлголтгүй бөгөөд сурагчдын ариун цэвэр, эрүүл ахуйд анхаарал хандуулах, нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чиглэлээр сургалтыг цогц байдлаар үр дүнтэй заах хэрэгцээ байна. Мөн эцэг, эхчүүд сургуулийн орчин дах эрүүл мэндтэй холбоотой үйл ажиллагааны талаар мэдээллийг тогтмол хүлээн авах хүсэлтэй байна. Сургуулийн орчинд сурагчдын, ядангуяа дунд болон ахлах ангийнханы эрүүл хооллолтод хяналт, зохицуулалт хийх шаардагатай байгааг дурдаж байв.

Сурагчдын зүгээс сургуулийн эмчийн өрөөний байршлыг мэддэг бөгөөд зарим нь үзүүлж байсан. Харин нийтлэг тулгамдсан асуудалд эмч бүрэн үзлэг хийхгүй, акт бичихгүй байх, шаардлагатай эм, багажгүй байдаг багтаж байна. Мөн сургуулийн орчинд идэх хүнсний бүтээгдэхүүний сонголт бага, амтгүй, хүртээмжгүй зэрэг ордог байна. Сумын сургуулийн сурагчдад гадаа модон жорлонд бие засах, өрөө танхим хүйтэн тухгүй байх, гар угаах угаалтуургүй байх, эмчийн өрөө хичээлийн өөр байранд байх асуудлууд тулгамдсаар байна.

Сурагчдын зүгээс эмчээс хүсэн хүлээж буй үйлчилгээнд хамгийн түрүүнд



ажлын байран дээрээ буюу өрөөндөө хэрэгтэй үед байх, хэрэгцээт эм тариа, үзлэгийн багаж хэрэгсэлтэй байхыг чухалчилсан. Харин сургуулийн зүгээс 6-9 дүгээр ангийнханыг үдийн хоолны хөтөлбөрт хамрагдуулах, хувцас солих өрөөтэй болох, нөхөн үржихүй болон сэтгэлзүйн талаар боловсрол, дэмжлэг зөвөлгөөг хувьчлан авах зэргийг хүсэн хүлээдэг байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

I. Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээний бодлого, эрхзүйн орчинг стандартчлах

- Сургуулийн эрүүл мэндийн хөтөлбөрийн үндэсний стандарт, удирдамжийг боловсруулах
- ДЭМБ-ын удирдамжийг нутагшуулах
- Төсвийн зохистой хуваарилалтаар хэрэгжүүлэх төлөвлөгөө
- Сурагчдын эрүүл мэндийн карт зэрэг эрүүл мэндийн системчилсэн хяналтыг бий болгох, эрт илрүүлэлт, менежментийг хөнгөвчлөх шийдлүүдийг эрэлхийлэх

II. Сургуулийн дэмжлэгт орчин, биет нөөц, хангамж

- Тусгаарлах өрөө, ор, тоног төхөөрөмж зэрэг өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай багаж хэрэгсэл, эм, хэрэгслийг тогтмол нийлүүлэх
- Амрах, биеийн тамирын дасгал хийх анги танхимыг бий болгох
- Эмнэлгүүд дэх өсвөр үеийнхний эрүүл мэндийн кабинит зэрэг сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой асуудлыг хамтран шийдвэрлэх төлөвлөлтийг дэмжих
- Тусгай хэрэгцээтэй сурагчдад зориулсан сургуулийн орчин дох үйлчилгээ авах нөхцөл, хүртээмжийг нэмэгдүүлэх

III. Хүний нөөц, үйл ажиллагаа, дэмжлэг

- Сургуулийн эмчийн гүйцэтгэх үүргийн тодорхойлолт, орон тооны нормыг сургууль тус бүрийн онцлог, нөхцөл, хэрэгцээ, судалгааны үр дүнг харгалзан шинэчилж, хэлэлцэж, эцэслэн



боловсруулах

- Сургуулийн эмч нарын зохих орон тоог үнэлэхдээ сурагчдын тоо, түүнчлэн сургуулийн барилга байгууламжийн зай, байршил, орчин зэргийг харгалзан үзэх
- Сургуулийн эмч нарын цалингийн хэмжээг нэмэгдүүлэх, санхүүгийн болон нийгмийн нэмэлт дэмжлэг, туслалцаа үзүүлэхийг нэн тэргүүнд тавих, эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эмч нарын цалин хөлстэй уялдуулах
- Сургуулийн эмч нарт ажил мэргэжлийн дэмжлэг, урамшуулал урт хугацаанд бодлогоор дэмжиж хамрагдуулах

IV. Эцэг, эхийн үүрэг, оролцоо, хамтын ажиллагаа

- Эрүүл мэндийн цахим бүртгэл, тандалт, хяналт зэрэг сургуулийн үйлчилгээний чанар, үр дүнг хянахад Засаг даргын оролцоог холбогдох хууль тогтоомжид заасан байдаг ч холбогдох хэрэгжилтийн журам, баримт бичигт энэ асуудлыг тусгаагүй болно. Эмчийн ажлын байрны тодорхойлолтод сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой асуудлыг ЗДТГ, дүүргийн Засаг дарга, холбогдох төрийн байгууллагатай хамтран шийдвэрлэх, шийдвэрлэх ач холбогдолтой заалт оруулах талаар хэлэлцэх.
- Сургууль-багш-эцэг эхийн хамтарсан ажиллагаа (харилцан ойлголцол, шийдвэр гаргах) Сургууль нь эрүүл мэндтэй холбоотой үйл ажиллагаа, сурагчдын эрүүл мэндийн талаар эцэг эх, асран хамгаалагчдад мэдээлж, хамтын санаачилгад идэвхтэй оролцох, оролцохыг дэмжих ёстой.
- Гэрийн хүмүүжлийн асуудал (эцэг эхийн боловсрол, эрүүл хооллолт, дэмжлэг) Эцэг эхчүүд мөн хүүхдүүддээ эрүүл мэндэд тустай, шим тэжээлтэй хоолоор хангах, өглөөний цайг уулгах, өсгөн хүмүүжүүлэх зэрэг үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх
- Эцэг эхчүүд өөрсдөө эрүүл мэндийн боловсрол, зан үйлийг төлөвшүүлж, хүүхдүүддээ үлгэр дуурайл үзүүлэх, гэрт ариун цэврийг сахих замаар сайн зуршилийг бий болгох
- Сурагчдын нас, сонирхол, хэрэгцээнд тохирсон эрүүл мэндийн боловсрол олгох, улмаар сургуулийн бусад үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөртэй уялдуулан сургах дадал хэвшилд суулгахад анхаарах



ЗУРГАА. ЭХ СУРВАЛЖ

- [1] Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, ДЭМБ-ын Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээний удирдамж, 2021
- [2] НҮБ-ын Хүүхдийн сан, 2020
